# “ДОРНОД АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТ
## (2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.12.23 Чойбалсан хот

| № | Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Д/д | Агуулга | Төсөв, Хэмжих нэгж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин (2025 он) | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл, тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | | |
| 1 | Зорилт | 1.1 | “Ковид-19” халдварт цар тахлын улмаас эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийг хангана. | тоо | Халдварласан тохиолдол | 0 | 0 | Коронавируст халдварын тохиолдлын тоо энэ оны 11 сарын байдлаар 7101 тохиолдол бүртгэгдсэн. Нийт өссөн дүнгээр 26177 тохиолдол батлагдсан. Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс хилийн нэвтрэх цэгт халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тандалтыг идэвхжүүлж, 8 сарын байдлаар Эрээнцав боомтоор 1112, Ульхан боомтоор 786 иргэн Монгол улс руу нэвтэрч, шинж тэмдгийн тандалтаар амьсгалын замаар дамжих халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй байна. Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран 7 хоног тутам Мягмар гарагт аймгийн хэмжээний 26 сургууль, 36 цэцэрлэгүүдийн тандалтын багуудтай 8 удаа цахим хурлыг зохион байгуулж өвчлөлийн нөхцөл байдал, зөвлөгөө мэдээлэл өгч байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 7 хоног бүрийн Баасан гарагт 8 удаа цахим хурлыг зохион байгуулан эмнэлгийн нөхцөл байдал, өвчлөлийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцон, зөвлөгөө | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэдээлэл өгч байна.<br>Коронавируст халдварын нийт 24553 тохиолдол батлагдсан. Дэлхийн зарим улсад КОВИД-19 халдварын шинэ хувилбар бүртгэгдсэнтэй холбоотой хилээр орж ирж буй иргэдэд аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн хилийн нэвтрэх цэгт халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тандалтын ажлыг идэвхжүүлсэн. Энэ оны эхний 05 сарын байдлаар Эрээнцав боомтоор 230, Ульхан боомтоор 91 иргэн Монгол Улс руу нэвтэрч шинж тэмдгийн тандалтаар амьсгалын замаар дамжих халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй байна. | |
| 2 | Арга хэмжээ | 1.1.1 | ”Ковид-19” халдварт цар тахлын үед аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд ажлын байраа хадгалах, орлоготой байлгах үүднээс хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалтыг тогтмол зохион байгуулна. | тоо | Сургалт, сурталч илгаа, нөлөөлл ийн ажил | 78 | 100 | Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч, улаан загалмайн хорооны 66 сайн дурын ажилтнуудтай гэрээ байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран хүн ам олноор цуглардаг худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, үсчин, гоо сайхны газар, караоке, саун, кофе шоп, хүнсний дэлгүүр зэрэг 128 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, халдвараас урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 815 зөвлөмж байршуулсан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Аймгийн төвийн 12 сургууль, 21 цэцэрлэгүүдийн 315 багш, ажилчид 723 эцэг эхчүүдэд Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, томуугийн | 100 |
| | | | | тоо | Хамрагд сан хүн | 28730 | 30000 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дархлаажуулалттай холбоотой сургалт зохион байгуулж, өвчлөлийн нөхцөл байдал, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Төр болон орон нутгийн өмчит 35 аж ахуйн нэгж, байгууллагуудын 737 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Томуу, томуу төст өвчин болон Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг Орон нутгийн 4 телевизээр эмчийн зөвлөгөө, мэдээлэл, контент, 18 эрүүл мэндийн байгууллагуудын пейж хуудсаар дамжуулан иргэдэд тасралтгүй мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тайлант онд сургалт нөлөөллийн ажил 141, хамрагдсан хүний тоо 67510. | |
| 3 | | 1.1.2 | Үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлж худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх мэдлэг мэдээлэл олгох ажлыг зохион байгуулж хяналтыг сайжруулна. | тоо | Хяналт шалгалт | 0 | 4 | ШӨХТГ-ын орон нутаг дахь улсын байцаагч 2022 оны 10 дугаар сард томилогдсоноос хойш “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийг олон нийтэд сурталчлах, мэдээлэл хүргэх цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж 14 сумын Засаг дарга, 67 багийн Засаг дарга нар болон сумдын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, эрх зүйн хөтөч нарын нийт 109 албан хаагчийг хамруулсан байна. Сумдын эрх зүйн хөтөч нар ШӨХТГ-т гомдол гаргах, орон нутгийн байцаагчид хэрхэн хандах талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн видео танилцуулга бэлтгэн Аймгийн Засаг даргын хүрээний 25 агентлагт хүргэж ажилласан. Тус танилцуулгыг албан байгууллагууд мэдээллийн цаг, дотоод хурлаараа дамжуулан ажилтан, албан хаагчдадаа хүргэж нийт 1000 орчим хүнд танилцуулагдаад байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, нийлүүлэлт журмын дагуу хэвийн явагдаж байна. Эм хангамжийн байгууллагуудад худалдаалагдаж байгаа коронавиурст халдварыг эмчлэх вирусийн эсрэг эмийн нөөцийн мэдээллийг 7 хоног бүр нэгтгэн, | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дотоодын албан хэрэгцээнд мэдээ, мэдээллээр ханган ажилласан. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, урвалж оношлуурын нөөцийн мэдээллийг 7 хоногт 3-4 удаа burtgel.mohs.mn программд бүртгэж баталгаажуулан, холбогдох байгууллагуудыг шаардлагатай тоон мэдээллээр хангаж байна. | |
| 4 | | 1.1.3 | Хязгаарлалтын дэглэмийн үед аж ахуйн нэгж, байгууллагуудын саналд үндэслэн хот хооронд болон сумдын хүнс, эм эмнэлгийн хэрэгсэл, түлш шатахууны татан авалт, тээвэрлэлт, түгээлтийг оновчтой хэлбэрээр зохион байгуулж, нөөц бүрдүүлнэ. | 0 1 | Тээвэрлэлтийн бэлэн байдлыг хангасан эсэх | 0 | 1 | Баянтүмэн, Баяндун, Булган, Матад, Халхгол, Дашбалбар сумын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн тул харьяа сумын Засаг даргын шийдвэрээр хорио цээрийн дэглэм тогтоож, голомтын бүс нутгаас гарах тээврийн хөдөлгөөний тодорхой хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авч ажилласан. Хязгаарлалтын дэглэмийг хууль тогтоомж, заавар журмын дагуу мөрдүүлэн хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд байнгын хяналт тавьж бүртгэн ажилласны үр дүнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар малын өвчлөлгүй болж, хорио цээрийн дэглэмийг бүрэн цуцлаад байна. | 100 |
| 5 | | 1.1.4 | Халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор худалдаа үйлчилгээний байгууллагуудад үйлчлүүлэгчдийг бүртгэлжүүлэх ажлыг нэвтрүүлж, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавин өвчний тархалтыг хязгаарлана. | 0 1 | Худалдаа үйлчилгээний байгууллагуудад бүртгэлийн систем нэвтэрсэн эсэх | 0 | 1 | Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18, 41 дүгээр тушаалаар баталсан түр журмын хэрэгжилтийг худалдаа, үйлчилгээний газруудад хангуулах арга хэмжээ авч, бүртгэлийн QR кодыг үйлчлүүлэгчдэд ил харагдахуйц газарт байршуулж, бүртгэлийн кодыг бүрэн нэвтрүүлсэн. | 100 |
| 6 | | 1.1.5 | ”Ковид-19” халдварт цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Сая төг | Нөөцийн сан | 240.0 | 480.0 | Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төсвийн зардлын хязгаарт багтаан цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотойгоор аймгийн Засаг даргын нөөцийн санг 907.5 сая төгрөгөөр батлуулсан нь зорилтот түвшинтэй харьцуулахад 1.9 дахин | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | илүү байна. | |
| 7 | | 1.1.6 | Хязгаарлалтын дэглэмийн хүндрэлийг даван туулах зорилгоор орон нутгийн бизнес эрхлэгчдээс судалгаа авч эрсдэлийн менежмент боловсруулан хэрэгжүүлнэ. | 0<br>1 | Эрсдэлийн менежмент боловсруулан хэрэгжүүлсэн эсэх | 0 | 1 | Коронавируст халдвар "COVID-19" цар тахлын нөхцөл байдал аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хэрхэн нөлөөлж буй байдалд дүгнэлт хийх, ерөнхий түвшинг тогтоох судалгааг хийх ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2021 оны А/428 дугаар захирамжаар батлагдаж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |
| 8 | | 1.1.7 | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангана. | үнэлгээ | Эрсдэлийн үнэлгээний түвшин | Өндөр эрсдэлтэй | Бага эрсдэлтэй байлгах | “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой эрүүл мэндийн байгууллагууд коронавируст халдварын эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: Вирусын эсрэг эм 8 нэр төрөл 39795 ширхэг, Антибиотик эм 8 нэр төрөл, 45213 ширхэг, Дуслын шингэн 8 нэр төрөл 51620, Амилуулах тусламж үйлчилгээнд шаардлагатай эм бэлдмэл 5 нэр төрөл 343 ширхэг, Эмнэлгийн хэрэгсэл 11 нэр төрөл 68900 ширхэг, Хувийн хамгаалах хэрэгсэл 10 нэр төрөл 302000 ширхэг, ПГУ ялгах 2879, тодорхойлох 1958, түргэвчилсэн тест шүлс 1890, хамар залгиур 2600 ширхгийн нөөц бүрдүүлэн эмчилгээ, оношилгоонд хэрэглэж байна. | 100 |
| 9 | | 1.1.8 | Зоонозын өвчин судлалын төв байгуулж, хилийн боомтуудад тусгаарлах байр, ариутгалын пункт, тандалтын нэгж байгуулна. | 0<br>1 | Нэгж байгуулагдсан эсэх | 0 | 1 | Дорнод аймагт “Зоонозын өвчин судлалын төв” байгуулах үндэслэл, хүсэлтийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэн, Зооноз өвчин судлалын үндэсний төвийн захирал, удирдлагуудад албан бичгээр хүргүүлэн. Коронавируст халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг үнэлэн аймгийн хэмжээнд 5 хилийн боомтын нэвтрэх | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэгт тусгаарлах байр, ариутгалын пунктийг түр хугацаагаар байгуулан бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Зооноз өвчин судлалын үндэсний төвөөс Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.3.2-т заасан арга хэмжээний хүрээнд 2022 онд “Зоонозын өвчин судлалын төв” (ЗӨСТ)-ийг 4 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгж байгуулах”-аар тусгагдсаны дагуу Дорнод аймгийн төвд Зоонозын өвчин судлалын төв болон Тандалтын нэгжийг хилийн Хавирга авто замын боомтод байгуулахаар 2023 онд Засгийн газрын тогтоол гаргуулж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Тайлант онд нэгж байгуулагдаагүй. | |
| 10 | | 1.1.9 | Газрын тос, уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж эдийн засгийн хүндрэлийг давах ажлын хүрээнд ”Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлж, бүтээгдэхүүн тээвэрлэлтэд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг чанартай гүйцэтгэж, хяналтыг сайжруулна. | хувь | Журмын хэрэгжилт | 0 | 100 | Өвдөг-Баянхошуу хилийн боомт дээр “Ногоон гарц” түр журам хэрэгжиж газрын тосны чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны газрын тосны экспортын үйл ажиллагааг Монгол Улсын шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ыг зохион байгуулж байгаад 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс БНХАУ-ын хил орчмын нутагт цар тахлын тохиолдол гарснаар хил хаагдаж, өнөөдрийг хүртэл хэвээр байна. Эрээнцав, Баянхошуу хилийн боомт дээр “Шинь шинь” ХХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК-ын дэмжлэгтэйгээр ариутгалын функт барьж ашиглалтад оруулж, Газрын тос, уул, уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байна. | |
| ХОЁР. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ<br>Үндэсний бахархал, эв нэгдэл | | | | | | | | | |
| 11 | Зорилго | 2 | Эх хэл, түүх, өв соёлоо эрхэмлэн дээдлэх, эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад өвлүүлж, урлаг соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | хувь | Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж | 46.8 | 52.0 | Эх хэл, түүх, өв соёлоо эрхэмлэн дээдлэх, эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад өвлүүлэх зорилгоор Соёлын ажилтны уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, бүх сумын мэргэжлийн ажилтнууд оролцсон, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор дугуйлан секцүүд ажиллуулж, 290 гаруй хүүхдүүдийг хамруулсан. “Үл бүдгэрэх их өв” 2022 төсөл амжилттай хэрэгжиж, СББӨ-ийн 5 төрлөөр сургалт, хэлэлцүүлэг, уралдааныг Соёлын яам, аймгийн Засаг даргын тамгын газар, ШУАкадемийн Хэл, зохиолын хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, 330 гаруй ардын авьяастан, анхлан суралцагч, хүүхэд багачууд, багш сурган хүмүүжүүлэгч нарыг оролцуулсан. Соёл урлагийн байгууллага, уран бүтээлчид, ардын авьяастнуудыг олон улс, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний номын баярын өдрүүдийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, 3200 гаруй иргэд олон, нийт оролцсон. “Уламжлалт боловсрол” төслийн хүрээнд “Зүйр цэцэн үгийн хэрэглээ” уралдааныг зарлаж, 254 хүүхдийн бичлэгийг хүлээн авч шилдгүүдийг тодруулсан. Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Аймгийн Хөгжимт драмын театрын хамт олон “Нүдтэй Наран тамга” хөгжимт жүжгийг туурвиж, 17 удаагийн тоглолтоор Дорнод аймгийн 8000 мянга гаруй, хүүхэд, залуус, иргэдэд толилуулсан. Соёлын орон зай, Соёлын бүтээлч сарын хүрээнд сум тус бүр хүүхэд залууст зориулсан соёлын олон талт үйл ажиллагаа зохион байгуулж, соёлын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. | |
| 12 | Зорилт | 2.1 | Үндэсний өв соёлыг өвлүүлэн хөгжүүлж, соёлын үнэт зүйлсийг бий болгох, соёл, урлагийн үйлчилгээг өргөжүүлнэ. | хувь | Хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ | 80 | 100 | Соёлын биет бус өвийн төрлүүдийг өвлүүлэн уламжлуулж, орон нутгийн онцлогт өв соёлыг хүүхэд залууст түгээн дэлгэрүүлж, шилдгүүдийг тодруулан алдаршуулах зорилгоор "Үл бүдгэрэх их өв" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 330 гаруй ардын авьяастан, анхлан суралцагч, хүүхэд багачууд, багш сурган хүмүүжүүлэгч нарыг оролцуулж, төслийн хүрээнд сургалт, хэлэлцүүлэг, уралдаан зохион байгуулагдсан. Соёлын биет бус өвийн улсын үзлэгийг 13 суманд зохион байгуулж, 37 өв тээгчээс асуулга, судалгаа авч бичлэгээр баримтжуулан, шаардлага хангаж буй 27 өв тээгчийг СББӨ-ийг өвлөн уламжлагчаар бүртгэх шийдвэр гаргасан. Соёл, урлагийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд Музейн боловсролын хөтөлбөр, Хөгжимт драмын театрын хөгжмийн дугуйлан, соёлын өвийг сурталчлах цахим контент зэрэг ажлуудыг төлөвлөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цахим болон танхимын хэлбэрүүдээр үзүүлсэн. Хөгжимт драмын театрын шинэ уран бүтээл "Нүдтэй Наран тамга" хөгжимт жүжгийг аймгийн төвийн дундаас дээш ангийн 3000 гаруй хүүхдүүд үзэж, гол санаа, төрсөн сэтгэгдэл зэргийг хичээлийн танхим болон цахим орчинд хуваалцсан. Мөн Үндэсний өв соёлыг өвлүүлэн хөгжүүлж, соёлын үнэт зүйлсийг бий болгох зорилгоор "Алтаргана", "Баргажин", "Алтан дөрөө", "Хатагин", "Эв мод"-ны наадмуудыг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 43,7 мянган хүүхэд, залуус, ахмад буурлууд хамрагдаад байна. | 100 |
| 13 | Арга хэмжээ | 2.1.1 | Соёл, урлагийн мэргэжлийн байгууллагуудын уран бүтээлд | тоо | Мэргэжлийн | 2 | 8 | Соёл, урлагийн мэргэжлийн байгууллагууд үндэсний бахархал, уламжлалт өв соёлоо | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусган хэрэгжүүлнэ. | | байгуулл агын туурвиса н томоохо н уран бүтээл | | | дээдлэх, сэргээх, өвлүүлэн уламжлуулах агуулгатай олон нийт рүү чиглэсэн олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1.Аймгийн Хөгжимт драмын театрын шинэ уран бүтээл "Нүдтэй Наран тамга" хөгжимт жүжиг, "Миний бяцхан шүдний аялал" хүүхдийн хүүхэлдэйн жүжиг, О.Оюунцэцэгийн "Дууны хорвоо" уран бүтээлийн тайлан тоглолтуудыг 21 удаагийн тоглолтоор 9600 гаруй үзэгчдэд,<br>2.Музейн Мөнхөд дурсах алдар нүүдлийн үзэсгэлэн, Музейд нэг удаа цахим уралдаан, боловсролын хөтөлбөрүүдээр 3400 гаруй хүүхэд залууст,<br>3.Номын сангийн Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний бахархал-Цагаан сар хөтөлбөрөөр 2000 гаруй уншигчдад, нийт 15000 гаруй ард иргэдэд тус зорилтын хүрээнд хүрч үйлчилсэн.<br>4.Аймгийн Баяр наадмын Хүндэтгэлийн тоглолтод Хөгжимт драмын театрын уран бүтээлчид үзэгч олондоо зориулан үндэсний бахархлыг тусгасан цоо шинэ уран бүтээлүүдээ үнэ төлбөргүйгээр толилуулсан.<br>5.Аймгийн Музей Ардын зураач, Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн, зураач Гэлэгийн Одонгийн уран бүтээлийн "Монголын сайхан орон" уран зургийн үзэсгэлэнг 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд зохион байгуулж, том хүн 250, 12 сургуулийн 1420 сурагч үзэж, сонирхсон.<br>4."Нийгмийн цогц явуулын үйлчилгээ" төсөл арга хэмжээний хүрээнд Хөгжимт драмын театрын уран бүтээлчид "Бригад-13" шилдэг уран бүтээлийн тоглолт, "Мангасуудын хаан" хүүхдийн жүжгийг Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал сумдын иргэдэд 5 удаагийн тоглолтыг тус тус зохион байгуулж, нийт 2224 орчим үзэгчдэд хүргэсэн. | |
| 14 | | 2.1.2 | Музейн сан хөмрөгийг баяжуулж, үзмэр үйлчилгээний | тоо | Хэрэгжү үлсэн | 2 | 6 | Аймгийн Музей 1,0 сая төгрөгийн төсвөөр 4 нэр, төрлийн үзмэр авч баяжуулалт хийсэн. Баян- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, орчин нөхцөлийг сайжруулна. | | хөтөлбөр, арга хэмжээ | | | Уул суманд “Ахмадаа сонсъё” уулзалтыг зохион байгуулж, өөрт хадгалагдаж буй эд өлгийн зүйлээ хандивлах аян өрнүүлж, одоогийн байдлаар 2 ахмадаас 3 ширхэг үзмэр авч, баяжилт хийгээд байна. Олон Улсын Музейчдын өдрийг тохиолдуулан аймгийн Музей, Халхгол сумын Ялалт музей хамтран “Мөнхөд дурсах алдар” үзэсгэлэнг Хэрлэн суманд зохион байгуулав. Ялалт музей, аймгийн Музей, Орон нутаг судлах танхимын ажилтнууд иргэдийн гар дээр байгаа эд өлгийн зүйлсийг судлах, бүртгэх ажлыг байнга явуулж байна. Үйлчилгээний чанар, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн Музей болон сумдын Орон нутаг судлах танхимуудад камержуулалт хийгдэж, үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 54,8 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Музейн үзмэрийн төрөл, зүйлийг нэмэгдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Түүхт нутгаар аялахуй” виртуал музей төсөл хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтыг зарлан, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгүүлж байна. |
| 15 | | 2.1.3 | Хүүхэд, залуучуудад эх хэл, түүх, өв соёлыг сурталчлах үйл ажиллагаануудыг зохион байгуулна. | тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 1 | 9 | 1.“Үндэсний бичиг үсгийн баяр”-аар Хэрлэн суманд их эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн хөшөөнд цэцэг өргөн, “Эртний соёлын өв” судрын үзэсгэлэн, аймгийн монгол бичгийн багш нар, сурагчдын “Хосгүй эрдэм” бүтээлийн үзэсгэлэн болон монгол бичгээр хэвлэгдэн гарсан ном, зохиолуудыг олон нийтэд сурталчлахын зэрэгцээ Ц.Дамдинсүрэнгийн намтар, түүх, зохиол бүтээлтэй танилцуулах, ном унших сэдэл тэмүүллийг төрүүлэх зорилгоор “Эх хэлээ дээдэлье” арга хэмжээ зохион байгуулж, 250 орчим хүүхдүүд, багш нар оролцсон.<br>2.Ерөнхий боловсролын сургууль тус бүр 2 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дугаар цагийн хичээлээр Ц.Дамдинсүрэнгийн намтар, уран бүтээлийг анги удирдсан багш нараар сурталчлан таниулсан. Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд монгол бичгийн уралдаан зохион байгуулсан.<br>3.Бага насны хүүхдэд зориулан аймгийн төв Номын сангаас "Үлгэрийн цаг" видео контент хийж байгаа бөгөөд 16 үлгэрийг цахим болон танхимаар 1417 хүүхэд үзээд байна. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн Музей, Халхгол сумын Ялалт музей хамтран "Мөнхөд дуурсах алдар" нүүдлийн үзэсгэлэнг Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиуд, Баянтүмэн, Булган, Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн, Чойбалсан сумд зэрэг нийт 33 удаагийн нүүдлийн үзэсгэлэн, боловсролын ажил зохион байгуулсан. Үүнд нийт Цэргийн албан хаагч 328, Төрийн албан хаагчид 47, сурагчид 177, иргэд 106, нийт 657 хүнд хүрч үйлчилсэн. | |
| 16 | | 2.1.4 | Иргэд, олон нийтийн оролцоотой соёлын өвийг хамгаална. | тоо | Зохион байгуулсан ажил, үр дүн | 2 | 8 | 1.Чулуун соёлын өвийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Соёлын яам, СӨҮТөв хамтран зохион байгуулсан "Зүүн бүс нутгийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах" ажлын хүрээнд Улаанбаатар Их Сургуулийн Түүх, археологийн тэнхимийн ажлын хэсэг Дорнод аймагт 2022 оны 04 дүгээр сард 13 суманд ажиллан түүх дурсгалт газруудтай танилцан Баян-Уул, Халхгол сумдад чулуун өвийг шинээр бүртгэсэн. 2.Халхгол сумын 2 дугаар баг "Тамсаг булаг"-ийн нутагт орших, түүхэн дурсгалт газарт зөвшөөрөлгүй малтлага хийж буй тухай мэдээлэл иргэдээс ирсний дагуу 04 дүгээр сарын 22-ны өдөр Ялалт музей, Соёлын төвийн ажилтнууд газар дээр нь ажиллаж, Дорнод аймгийн харъяалалтай, 2 автомашинтай, 8 иргэн Тамсагийн сүм орчимд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хууль бус хайгуул хийж байсныг таслан зогсоож, авто машины бичиг баримт 7 төрлийн эд өлгийн зүйлийг баримт болгон хурааж, Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. Цагаан-Овоо сумын 2 дугаар багийн нутаг дахь Дэрдэвийн арын манхан орчмоос олдсон түүх, соёлын өвийн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх зорилгоор Соёл, урлагийн газар, аймгийн Музей, Ялалт музей, нутгийн иргэдийн хамтарсан ажлын хэсэг 07 дугаар сарын 28наас 08 дугаар сарын 08-ны хооронд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн дундад зууны салбарын ажлын хэсэг, Дорнод аймгийн Соёл, урлагийн газар, аймгийн Музейтэй хамтран малтлага, судалгаа, хайгуулын чиглэлээр ажиллаж, Дэрдэвийн манханд 2 газар хайгуул судалгаа хийж, шинэ чулуун зэвсгийн үеийн олдворын зүйлийг олж бүртгэн баримтжуулсан. Тус түүхэн дурсгалт газрын хамгааллын ажлыг тус нутгийн оршин суугч 2 иргэнтэй гэрээ байгуулан харгалзаж, хамгаалж байна. Сэргэлэн сумын хамгаалалтад байдаг 4 түүхэн дурсгалт газрыг хамгаалах гэрээ байгуулж, нутгийн иргэдэд гэрчилгээ гардуулаад байна. | |
| Нүүдлийн соёл иргэншилт Монгол | | | | | | | | | |
| 17 | Зорилт | 2.2 | Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ: | хувь | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 80 | 100 | Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчлах ажлын хүрээнд Соёлын биет бус өвийн зүйлүүд, өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, орон нутгийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах зорилгоор аймгийн “Нүүдэлчин Монгол” СББӨвийн наадмын 1 дүгээр шатны шалгаруулалтыг суманд зохион байгуулж, 2 дугаар шатны шалгаруулалтыг 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус наадмаас шалгарсан өвлөн уламжлагч, ардын авьяастнууд Горхи Тэрэлжийн байгалийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цогцолбор газарт зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд оролцсон. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид амжилттай оролцож, “Уламжлалт арга ухаан”, “Мал маллах арга ухаан” ай савын төрөлд Цагаан-Овоо сумын малчин, Монгол Улсын аварга малчин, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч Д.Пүрэв, гэргий А.Басагмаа нарын уламжлалт “Зөөдөл” буюу морь, тэмээн тэргээр нүүдэл хийдэг зан үйл тэргүүн байр эзэлж, “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” ай савын төрөлд Дорнод аймгийн Баян-Уул сумын Соёлын төвийн дэргэдэх “Улаалзай” дугуйлангийн сурагч Өлзийбатын Баярхүү, Ганбатын Буяндэлгэр нар “Буриад ардын эртний таавар мэтгэлцээн”-ээр энэхүү наадмын шилдэг үзүүлбэрээр шалгарч, хоёул уг наадмын “Өсвөрийн шилдэг өвлөн уламжлагч” алтан медалиар шагнагдсан. | |
| 18 | Арга хэмжээ | 2.2.1 | Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай иргэнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | хувь | Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн | 100 | 100 | Уламжлалт цагаан сарын баяраар монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Цагаан сарын бэлгэдэл” номоос Цагаан сараар цээрлэх ёсон, Тавгийн идээ засах, Битүүлэх, Шинэлэх ёс гэсэн 4 видео контентыг бэлтгэн, цахимд байршуулж, 1374 хүнд хүргэсэн. Соёлын биет бус өвийн төрлүүдийг өвлүүлэн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэн орон нутгийн онцлогт өв соёлыг хүүхэд залууст сурталчлах зорилготой “Үл бүдгэрэх их өв 2022” төслийг 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус төсөлд танхимын сургалт, эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг, уралдаан гэсэн 3 чиглэлээр 13 сумын 330 гаруй хүүхэд, залуус, ардын авьяастан, өвлөн уламжлагчид оролцсон. Соёлын боловсролыг иргэн бүрт уриан дор сумдын Соёлын төвүүд, Ялалт музейтэй хамтран орон нутгийн соёлын онцлогийг сурталчлах зорилгоор “Дорнод | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нутгийн соёлын өв” үзэсгэлэнг толилуулсан. Тус үзэсгэлэнд Баян-Уул сумаас “Буриадай өв соёлой үдэрлэг” үзэсгэлэн гаргаж, сумынхаа СББӨ тээгчид болон соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийнхээ бүтээлээр үзэсгэлэн дэлгэж, нийт 440 хүнд хүрч үйлчилсэн. “Хэрлэнгийн барьяа” уртын дууны чуулгаас зохион байгуулсан уртын дууны сургалтад 80 гаруй уртын дуучин хамрагдаж, аймгийн тахилгат “Хан Уул”-ын тайлгын ёслолд зориулж, “Хан Уул” дууг 28 дуучин дуулж, дуун тахил өргөж уул, ус, нутгийн ард иргэд, хуран цугласан наадамчдад хүндэтгэл үзүүлсэн. | |
| 19 | | 2.2.2 | Зүүн монголчуудын өв соёл, То-вангийн сургаал судалгааны төв байгуулна. | 0<br>1 | Төв байгуула гдсан эсэх | 0 | 1 | Аймгийн төсвийн тодотголоор 2022 оны төсвөөс хасагдаж, дахин санал хүргүүлж, 2023 оны Халхгол сумын орон нутгийн төсөвт 230,0 төгрөгөөр нэмэгдэж тусгагдсан. | 0 |
| 20 | | 2.2.3 | Халх, Буриад, Барга, Үзэмчин ястны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | тоо | Хэрэгжү үлсэн арга хэмжээн ий тоо | 1 | 4 | Халх угсаатны “Талын соёл” зорилтот төсөл эвент арга хэмжээний хүрээнд Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Дорнод аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр наадмыг 07 дугаар сарын 07-11ний хооронд зохион байгуулсан. Мөн уламжлал болгон зохион байгуулагддаг буриад, барга, үзэмчин, халх угсаатны зан үйлийн давтагдашгүй өвийг сэргээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилго бүхий “Алтаргана”, “Баргажин”, “Алтан дөрөө”, “Хатагин”, “Эв мод”-ны наадмуудыг 07 дугаар сарын 07-ноос 09 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнүүдэд нийт давхардсан тоогоор 43,7 мянган хүүхэд, залуус, ахмад буурлууд хамрагдаад байна. Угсаатны наадмуудаас буриад түмний Алтаргана наадам ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Агын буриадын тойрогт зохион байгуулагдснаараа онцлог бөгөөд тус наадамд манай аймгийн баг хамт олон ОХУ, Монгол Улс, БНХАУ, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Кыргызстан, Казакстан зэрэг улсуудад тархан суурьшсан буриад зон олонтой 11 төрөлд өрсөлдөж, 1 гранпри, 6 алт, 2 мөнгө, 1 хүрэл, 1 тусгай байрын шагнал хүртсэн амжилт үзүүлсэн. | |
| Монгол хэл, бичиг | | | | | | | | | |
| 21 | Зорилт | 2.3 | Монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | хувь | Иргэдийн монгол хэл, бичгийн хэрэглээний түвшин | 30 | 60 | “Монгол бичгээ суръя” төслийн хүрээнд 5 сургалт, 8 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн.<br>1.Аймгийн хэмжээнд монгол бичгийн 5 удаагийн сургалт зохион байгуулж, 2248 сурагч, иргэд, албан хаагчдыг хамруулан, үндэсний бичгийн чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>2.Монгол бичгийн “Бийрийн бичиг”, “Хичээнгүй бичиг”-ийн уралдаануудад Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 33 сурагч, Үндэсний бичгийн тэргүүний уншигч байгууллага шалгаруулах уралдаанд 23 албан байгууллагын 240 албан хаагч, 14 сумын Засаг даргын тамгын газар болон байгууллагын 305 албан хаагч, 34 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 435 албан хаагч буюу нийт 980 албан хаагч хамрагдаж үндэсний бичгээр унших чадвараа ахиулсан.<br>3.Жаран телевизтэй хамтран “Монгол бичгээ суръя” 20 цагийн теле хичээл, “Үндэсний өв” цуврал нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд түгээсэн ба Эртний соёлын өв” судрын үзэсгэлэн, аймгийн монгол бичгийн багш нарын “Хосгүй эрдэм” бүтээлийн үзэсгэлэн олон нийтэд толилуулсан. | 100 |
| 22 | Арга хэмжээ | 2.3.1 | Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ. | хувь | Сурлагын амжилт, чанар | Улсын дунджаас доошгүй | Улсын дунджаас дээш үнэлэгдэх | Монгол хэл, бичгийн бүх шатны боловсролын чанарыг нэмэгдүүлэх үүднээс монгол хэл, бичгийн багш нарын арга зүйн ажлыг жилд 6 удаа зохион байгуулж, 80 багш, мэргэжлээ дээшлүүлж, арга зүйг, туршлагаа 6 сургууль түгээн дэлгэрүүлсэн. Ерөнхий боловсролын 4 сургуулийн ахлах ангийн 120 сурагчид | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулснаар тухайн сургуулиудын Элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний шалгалтын дүн тодорхой хувиар ахисан. Монгол хэлний тухай хуулийн 3 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтын дагуу улсын хэмжээнд монгол хэл, бичгийн шалгалтыг зохион байгуулсан. Дорнод аймгаас ерөнхий боловсролын 18 сургуулийн 12 дугаар ангийн сурагч 801 сурагч, өмнөх оны 34 шалгуулагч, нийт 835 шалгуулагч шалгалтад орсон ба Монгол хэл, бичгийн шалгалтын дундаж үнэлгээ 521,4 хувийн гүйцэтгэлтэй улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн шалгуулагчдын дундаж гүйцэтгэл 526.4 хувьтай улсын дунджаас дээгүүр шалгагдсан ба нийт шалгуулагчдын 92.3 хувь нь 400-аас дээш оноотой шалгагдаж босго оноо давсан. Элсэлтийн ерөнхий шалгалтад улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж, монгол хэлний хичээлээр 6 дугаар байр эзэлж, 2 сурагч 800 оноотой шалгагдсан. Дорнод аймгийн ерөнхий боловсролын 26 сургууль, 2 мэргэжлийн сургууль, 1 их дээд сургуульд монгол бичгийн хичээлийг 9760 гаруй суралцагчдад мэргэжлийн 90 багш хичээл, үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/123 захирамжаар батлагдсан “Монгол бичгээ суръя” төслийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуульд 1000000 /нэг сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Амин бичиг” үндэсний бичгийн танхим тохижуулснаар сурагчдад сурах таатай орчин, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. “Тэргүүний уншигч” шалгаруулах уралдаанд 25 сургуулийн 114 сурагч хамрагдан үндэсний бичгээр унших чадвараа ахиулсан ба улсын чанартай “Тээгч-Түгээгч”, “Тэргүүний уншигч”, “Монголын сайхан бичигтэн” уралдаануудад сурагчид амжилттай оролцон | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 1-3 дугаар байрыг эзэлсэн. | |
| 23 | | 2.3.2 | Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ. | тоо | Төрийн албанд ажиллаж байгаа болон төрийн албаны шалгалтад оролцож буй иргэдэд зориулсан сургалтын тоо | 1 | жилд 2-оос дээш | Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, Дорнод их сургуультай хамтран, төрийн албаны нөөцөд бүртгүүлэх төрийн албан шалгалтад бүртгүүлсэн 133 иргэнд 3 өдрийн сургалт зохион байгуулж, монгол хэл, бичгийн зөв бичих, найруулга зүйн чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Сумдын салбар зөвлөлийн гишүүдтэй онлайнаар уулзаж, Үндэсний хэлний зөвлөлөөс хийж, хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл өгч, “Монгол хэлний тухай хууль”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ийг сум орон нутгийн хэмжээнд хэрхэн хэрэгжүүлэх, цаашид 2025 онд бүх нийтээр монгол бичигтэй болоход санал, санаачилгатай хамтран ажиллах зэрэг асуудлаар харилцан санал солилцлоо. Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Дорнод аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл хамтран зохион байгуулсан сургалтад Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв болон 12 сургууль, 4 цэцэрлэгийн 30 багш, Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн 18, 9 сумын 16, нийт 64 төрийн албан хаагч хамрагдан монгол хэлний зөв бичиг, үндэсний бичиг, уран бичгийн мэдлэг, чадвараа ахиулсан. | 70 |
| ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | | | |
| Боловсрол | | | | | | | | | |
| 24 | Зорилго | 3 | Хүн амын дундаж наслалтыг 72-т хүргэж, боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 90,0 хувьд хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | индекс | Хүний хөгжлийн үзүүлэлт | 0.726 | 0.77 | Хүний хөгжлийн индекс 2021 оны байдлаар 0,740 болж, өмнөх оныхоос 0,002-оор нэмэгдсэн. | 90 |
| 25 | Зорилт | 3.1. | Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | хувь | Ерөнхий боловсролын | 92.2 | 95.0 | Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэхээр цэцэрлэгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамран сургалт | | | барилгыг өргөтгөх, бүлэг нэмэх зэргээр хамран сургалтыг нэмэгдүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 3 дугаар баг, Баянтүмэн суманд цэцэрлэгийн 150 ортой барилга ашиглалтад орж, мөн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгт 2 бүлэг, Хэрлэн сумын 10 дугаар цэцэрлэгт "Дорнод бужин" цэцэрлэгийн 2 ангийг түрээслэж, 2 бүлэг шинээр нээж, хамран сургалтыг нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт 35 цэцэрлэгт 6948 хүүхэд хамрагдсан нь өмнөх оноос 524 хүүхэд нэмэгдсэн, хамран сургалт 85,2 хувь байна. Ерөнхий боловсролын хамран сургалт 97 хувьтай байна. | |
| 26 | Арга хэмжээ | 3.1.1. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 87,5 хувь байгааг 2025 онд 90 хувьд, бага боловсролын хамран сургалт 2020 онд 97,9 хувь байгааг 2025 онд 98,4 хувьд, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 93,5 хувь байгааг 2025 онд 98 хувьд хүргэнэ. | хувь | СӨБ, ЕБС-ийн хамрагдалт | СӨБ 87.5<br>ЕБС бага боловсрол 97.9<br>ЕБС суурь боловсрол 93.5 | СӨБ 90.0<br>ЕБС бага боловсрол 98.4<br>ЕБС суурь боловсрол 98.0 | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн бүлэг 8, дунд ангийн бүлэг 16-аар тус тус өмнөх жилээс өссөн үзүүлэлттэй. Сургуулийн бага ангийн хамран сургалтын цэвэр жин 99,2%, Дунд ангийн хамран сургалтын цэвэр жин 97,0%, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 97,0% байна. 2022-2023 оны хичээлийн жилд 35 цэцэрлэгт 6938 хүүхэд суралцаж байгаа ба сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2,6%-аар буурч, 85,1%-д хүрсэн. Сургуулийн бага ангийн хамран сургалтын цэвэр жин 99,2%, дунд ангийн хамран сургалтын цэвэр жин 97,0%, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 97,0% байна. | 70 |
| 27 | | 3.1.2. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролд бүрэн хамруулах орчин нөхцөлийг бүрдүүлж, бага ангийн багш нарын 50-аас доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцуулна. | хувь | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарын | 40 | 70 | "Тэгш хамруулах боловсролыг дэмжих", "Монгол Улсад тэгш хамруулах боловсролын багш бэлтгэх", "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах" төслүүдийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны газрын удирдлага, мэргэжилтнүүд болон 7 сургууль, цэцэрлэгийн 115 багшийг чадавхжуулах сургалтад | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийт бага ангийн багш нарт эзлэх хувь | | | хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог ялгаатай байдлын талаарх гарын авлага, видео хичээлийг сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэн, мэдээллээр хanган ажиллаж байна. Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь сургуульд багшаар бэлтгэгдэж байгаа оюутнуудад тэгш хамруулах боловсролын агуулга оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарыг чадавхжуулах чиглэлээр 10 багшийг сургалтад хамруулсан. Мөн “Зан авирын өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Аутизмын хамрах хүрээний оноштой хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдвүүдээр Польш Улсын багш нарын зохион байгуулсан цахим сургалтуудад Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 20 гаруй багш хамрагдсан. | |
| 28 | | 3.1.3. | Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмж, нийгмийн баталгааг хангана. | хувь | Нийгмийн баталгааны үр шим хүртсэн багш нийт багшид эзлэх хувь | 50 | 100 | Боловсрол, шинжлэх ухааны газраас багш нарын мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх чиглэлээр сургалт, арга зүйн ажил зохион байгуулах, хөдөлмөрийг бүтээмжийг үнэлж, урамшуулах ажлуудыг зохион байгуулан, удирдлага, арга зүйгээр хангасан ажиллаж байна. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ерөнхий боловсролын 22 сургуулийн 20 судлагдахууны 794 багш, бичгийн шалгалтад 12331 сурагч, сургуулийн өмнөх боловсролын 31 байгууллагын 220 багш, 6130 хүүхэд, 6130 эцэг эх тус тус хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ аймгийн дундаж 72,8-тай үнэлэгдсэн нь улс, орон нутгийн дунджаас 03,-1,1 оноогоор дээгүүр үнэлэгдсэн. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 126 багш 1 дүгээр түвшинд үнэлэгдэж 20-25 хувь, 211 багш 2 дугаар түвшинд үнэлэгдэж 10-15 хувийн урамшуулалд хамрагдсан. Аймгийн хэмжээнд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэргэжлийн хөгжлийн бүлгийн төлөвлөгөөнд 3 чиглэлийн хүрээнд 12 үйл ажиллагаа төлөвлөж, 26 ажилд 1306 багш, зорилтот болон сонголто сургалтад 3186 багш хамрагдаж, ажлын байрандаа мэргэжлийн хөгжлийн бүлгээр тасралтгүй хөгжиж байна. Боловсрол, шинжлэх ухааны газрын ажлын хэсэг 14 сумын 19 ерөнхий боловсролын сургуулийн 487 багш, 14 цэцэрлэгийн 168 багш, туслах багшид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. "Дорнодын багш" болзолт уралдааныг зохион байгуулж, шалгарсан бага боловсролын 4 багшид "Эрдэм" хөтөлбөрөөс тус бүр орон сууц худалдан авахад 20,0 сая төгрөгийн урьдчилгаа олгож, 5 багшид 500,000 төгрөгөөр урамшуулсан. Багш нарын туршлага солилцох, уралдаан, тэмцээнд оролцох 4 үйл ажиллагаанд 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 29 | | 3.1.4. | Газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлж, тэгш байдлыг хангана. | тоо | Шинээр баригдсан Сургууль, цэцэрлэг, дотуур байрны тоо | 6 | 13 | Боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль 2, цэцэрлэгийн 3, дотуур байр 4, спорт заал 1, нийт 10 барилга 40–95 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Өмнөх тайлангаас хойш Хэрлэн сумын 3 дугаар баг, Баянтүмэн суманд 2 цэцэрлэг ашиглалтад оруулаад байна. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын саналд сургуулийн барилга 6, цэцэрлэгийн барилга 6, спорт заал 1 оруулахаар саналыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст танилцуулж, зардал үр дүнгийн шинжилгээ, зураг төсөв, газрын бичиг баримт, техникийн нөхцөлүүдийн хамт Сангийн яамны системд бүрэн оруулаад байна. | 100 |
| 30 | | 3.1.5 | Хүүхэд, залуучууд, иргэдэд уламжлалт өв соёл, ёс зүй, байгаль экологи, түүх, гадаад хэл, урлагийн боловсрол | хувь | Төслийн хэрэгжилт | 0 | 100 | Монгол өв уламжлалд суралцах, байгаль дэлхийгээ хайрлах, эх оронч хүмүүжил аян, аялал, цахим музей үзэх үйл ажиллагаанд 3337 сурагч, 2 сургууль 30 эцэг эх, асран | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | олгох, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | хамгаалагч, 14 багшийг, сургалтад 3837 сурагч, Монголын нүүдэлчин ахуй амьдрал, зан үйл, уламжлалыг таниулах өдөрлөг, аянд 2593 сурагч, 358 эцэг эх, асран хамгаалагч, 14 багшийг хамруулсан. Цагаан зээрийн үнэ цэнэ, ач холбогдлыг сурталчлан таниулах “Янзган хүрээг хайрлаарай” аянд Дорнод аймгийн ерөнхий боловсролын 8 сургуулийн 8 багш, эко клубийн 24 сурагч оролцон, цагаан зээр хамгаалах чиглэлээр өөрийн орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцуулан, шийдвэр гаргагчидтай хамтарч тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн, нэгдсэн уриалга гаргаж санал бодлоо илэрхийллээ. “Хийн түлш-Бидний ирээдүй” сэдэвт сургалтад ерөнхий боловсролын 12 сургуулийн 8-12 дугаар ангийн 366, эссе бичлэгийн уралдаанд 35 суралцагч, “Дагуурын” дархан газрын эко бүс нутгууд болон байгалийн орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, байгалиа хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх, уран зургийн төсөөлөх болон бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор гар зургийн уралдаанд 5-18 насны 20 хүүхэд хамрагдсан. Бүх шатны сургууль, цэцэрлэгүүд “Их Эзэн Чингис хааны эш хөргийг залах” арга хэмжээг зохион байгуулж, “Монгол бахархал” аяны хүрээнд олон талт ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Үүнд: Бага ангийн 4162, цэцэрлэгийн 6500 хүүхэд түүхэн дуу, бага ангийн 3536, цэцэрлэгийн 5800 хүүхэд шүлэг, яруу найраг, бага ангийн 506, цэцэрлэгийн 2456 хүүхэд бүжиг сурч, бага ангийн 1968 хүүхэд домог ярьж чаддаг болсон. Мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах ангийн 6001 суралцагч эх түүхээ сурталчилсан 2967 хэлц үг, уриа үг, постер зохион, 142 видео контент хийж, “Монголын нууц товчоо”-г хэн сайн мэдэх вэ?, “Шагайн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | харваа” тэмцээн, Тик ток бичлэгийн уралдаан, “Үндэсний бичгээ эрхэмлэе” үзэсгэлэн, Монголын нууц товчоог хүндэтгэх ёслолын ажиллагаа зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, сурталчилсан. | |
| 31 | | 3.1.6 | Их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, бүх шатны хувийн хэвшлийн сургалтын байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, үйл ажиллагааг дэмжинэ. | тоо | Хамтран ажиллас ан хувийн байгуулл ага | 8 | 12 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс “Мэргэжил бүхэн сайхан” аяныг зохион байгуулж, аймгийн төв, хөдөөгийн ерөнхий боловсролын сургуулийн 9, 12 дугаар ангийн 750 сурагч, Хэрлэн сумын багуудын ажил мэргэжилгүй залуучууд, аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, ажилтнууд, хэвлэл мэдээллийн байгууллага болон түншлэгч 60 гаруй байгууллагын 75 төлөөлөл оролцсон. Сургуулиа сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсны үр дүнд насанд хүрсэн ажил мэргэжилгүй 20 гаруй иргэд тус сургуульд элсэн мэргэжил эзэмшихээр суралцаж байна. Политехник коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь багш солилцоо, харилцан туршлага судлах, магадлан итгэмжлэл дээр хамтран ажиллах чиглэлээр байнгын хамтын ажиллагааг өрнүүлсэн. “Нутгийн ирээдүй” тэтгэлгээр дутагдалтай мэргэжлийн багшийг бэлтгэх ажлыг Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулж байна. “Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” (MONGWBL) төслийн хүрээнд Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийн туршилтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Хятад хэлний орчуулга-аялал жуулчлалын хөтөлбөрөөр суралцаж буй 14 оюутан урт хугацааны цалинтай дадлагыг гүйцэтгэж байна. Мөн оюутнууд “Дорнод аялал жуулчлалын нэгдэл” ТББ-аас явуулж буй | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч”-ийн 32 цагийн сургалтад үнэ төлбөргүйгээр хамрагдаж байна. | |
| Эрүүл мэнд | | | | | | | | |
| 32 | Зорилт | 3.2. | Хүн амын дундаж наслалт 2020 онд 69.6 жил байгааг 2025 онд 72,0 жилд хүргэнэ. | тоо | Хүн амын дундаж наслалт | 69,6 | 72 | Хүн амын дундаж наслалт 2021 оны жилийн эцсийн байдлаар 70.23 болж, өмнөх оныхоос 0,45 насаар, эрэгтэйчүүд 0,41 эмэгтэйчүүд 0,47 насаар нэмэгдсэн. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 8,66 болж, 0,6 насаар нэмэгдсэн тул зөрүүг бууруулах, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байна. | 100 |
| 33 | Арга хэмжээ | 3.2.1 | Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | тоо | Хамтран ажиллас ан байгуулл ага | 10 | 20 | Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит аж, ахуй нэгж, хувийн байгууллагуудад халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг давхардсан тоогоор 51 байгууллагын 2000 орчим ажилтан, албан хаагчдад мэдээлэл өгч, 11 төрлийн 2100 гарын авлага түгээсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/23 дугаар захирамжаар хэрэгжиж буй “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” 2022 оны 6-9 дүгээр саруудад хугацаанд 13 сумдад ажиллаж, амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн нийт 3000 гаруй мэдээлэл, сурталчилгааны материалыг иргэдэд түгээсэн. Тайлант онд 51 байгууллага хамтран ажилласан. | 70 |
| 34 | | 3.2.2. | Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна. | хувь<br><br>Промиль | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагд алт<br><br>Нас баралты н | 84,2<br><br>5,3 | 80,0<br><br>5,0 | Энэ онд урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 129507 иргэн хамрагдаж, 60,5 хувьтай байна. Үүнд: артерийн гипертензийн хамрагдалт 81,7, чихрийн шижин 80,6 өмнөх оны мөн үеэс 22,1 хувиар, хөхний өмөнгийн илрүүлэг 74,8, өмнөх оны мөн үеэс 26,9 хувиар, умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг 37,3 өмнөх оноос 4,6 хувиар тус тус нэмэгдсэн. Эрүүл мэндийн сайдын 139 дүгээр тушаалаар | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түвшин | | | “Хүн амын нас, хүйс, эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг”-ийн арга хэмжээний хүрээнд хамрагдвал зохих иргэдийн 55,8 хувийг хамруулахаар төлөвлөж, 0-18 насны хүүхдийн 43,7 хувь, 18-аас дээш насны иргэдийн 19,9 хувь, нийт иргэдийн 34,3 хувь нь хамрагдаад байна. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хаягаар иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол болон бусад мэдээллийг түгээсэн. Хүн амын сэргийлж болох нас баралт 321 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 110 тохиолдлоор буурч, 1000 хүн амд 3,8 промиль байна. | |
| 35 | | 3.2.3. | Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ. | тоо | Шинээр нэвтрүүлсэн технологи | 2 | 5 | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд зүрхний титэм судсан доторх оношилгоо эмчилгээг хийх лаборатори байгуулагдаж, 4 сарын хугацаанд 50 гаруй иргэдэд оношилгоо хийж, судсанд тэлэгчийг амжилттай байршуулсан. Улсын I, II, III төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй судсан дотуурх мэс заслын мэргэшлийн үндэсний баг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ажиллаж тус төвд суурилагдсан Ангиографийн аппаратын бүрэн ажиллагааг шалган танилцахын зэрэгцээ элэгний HCC хавдартай таван тохиолдолд хавдрын судас бөглөх эмчилгээг, зургаан тохиолдолд зүрхний титэм судасны катетерт оношилгоо, архаг шигдээстэй хоёр тохиолдолд титэм судасны нарийслыг тэлэх судсан дотуурх стент ангиопласти мэс засал эмчилгээг тархины судасны эмгэгтэй болон тархины цус харвалтын оноштой нийт 30 өвчтөнд үзлэг зөвлөгөө өгснөөс тархины судасны цүлхэнтэй дөрөв, судасны бөглөрөлтэй хоёр, тархины мэс заслын дараах хяналтын хоёр, сэхээн амьдруулах тасагт эмчлүүлж буй хоёр тохиолдол, нийт 13 тохиолдолд тархины судсан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дотуурх катетерт ангиографийн оношилгоо хийн, газар дээр нь тусламж үзүүлсэн. Шинээр 3 технологи шинээр нэвтрүүлсэн. | |
| 36 | | 3.2.4. | Орон нутагт яаралтай тусламжийн нэгжийг байгуулан тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ. | тоо | Парк шинэчлэлт | 3 | 8 | Яаралтай тусламжийн үндэсний сүлжээнд холбогдож эрсдэлтэй бүсэд яаралтай тусламжийн цэг шинээр байгуулахаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/502 дугаар тушаалаар “Яаралтай тусламжийн жишиг цэгт нийлүүлэх тоног төхөөрөмжийн жагсаалт”-аар Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвд 4 нэр төрлийн 9,9 сая төгрөгийн үнэ бүхий яаралтай тусламжийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Гурвансагал, Сэргэлэн сум, Хэрлэн сумын “Асралт-Үйлс” өрхийн эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг 2022 онд аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагуудын хориглох заалтаар нөөцөд бүртгэгдэж буй автомашинаас шийдвэрлээд байна. | 100 |
| 37 | | 3.2.5. | Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ. | тоо | Алсын зайн оношилгоо | 2 | 5 | Алсын зайн оношилгоог ашиглан үйлчлүүлэгчид зөвлөгөө авах, эмчилгээний асуудлыг шийдвэрлэхээр насанд хүрэгчдэд УХТЭ, хүүхдэд ЭХЭМҮТ-тэй хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд 12 удаа зөвлөгөө авсан бөгөөд аймгийн хэмжээний 13 сумын эмнэлэгтэй утсан холбоогоор харилцаж, дуудлагын эмч очтол хүнд өвчний эмчилгээний асуудалд зөвлөгөө өгч ажиллаж байна. Тайлант онд 12 алсын зайн оношилгоо хийсэн. | 100 |
| 38 | | 3.2.6. | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаг, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтыг сайжруулна. | хувь | Эмийн хангалт | 80 | 88 | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2022 онд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, нийлүүлэлт сар бүрийн тогтмол хугацаанд хийгдэж байна. Үнэлгээний хороо нь эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ болон чанарын үзүүлэлтийн оноог үндэслэн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, боломжийн үнэтэй эм нийлүүлэх 16 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан эмийн бүртгэл, хангалт, нийлүүлэлт, зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна. Эмийн хангалт 90 хувьтай байна. | |
| 39 | | 3.2.7 | Орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 2 | 5 | 1.Орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөгөөг 3 жилийн хугацаатай төлөвлөж, нэн шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургаж хүний нөөцийг бүрдүүлж байна.<br>2.2022 онд 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн үндсэн, мэргэшүүлэх болон мэргэжил олгох сургалтад суралцаж байна. Тайлант хугацаанд анхан шатны нэгжид ажиллаж байгаа 78 эмнэлгийн мэргэжилтнүүдэд 39,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дашбалбар сумаас зохион байгуулж буй Сумын залуучуудын орон сууц хөтөлбөрт Эрүүл мэндийн төвийн 5 ажилтан хамрагдаж, амьдрах нөхцөлөө сайжруулсан.<br>3.Хөлөнбуйр, Баян-Уул, Булган, Дашбалбар, Сэргэлэн сумд малжуулах төслийг 2006 оноос хойш хэрэгжүүлж, 2022 онд нийт 5 ажилтанд 50 гаруй бог малыг 1-2 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэн үр төл, ашиг шимийг хүртээх боломжоор хангасан.<br>4.“Би сувилагч” төсөлт уралдааныг 3 үе шаттай зохион байгуулж, эхний 3 байранд шалгарсан Баянтүмэн сумын сувилагч Б.Оюунжаргал, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн сувилагч С.Батчимэг, Хэрлэн сумын “Ягаан цээнэ” өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч Ч.Энхзаяа нарыг орон сууц худалдан авахад нь | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж, тус бүр 20,0 сая төгрөгөөр, уралдааны гуравдугаар шатанд шалгарсан 9 сувилагчийг тус бүр 400000 төгрөгөөр шагнаж, урамшуулсан. | |
| 40 | | 3.2.8 | Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. | хувь | Спортоор хичээллэж буй иргэдийн нийт хүн амд эзлэх хувь | нийт иргэдийн 1.3 хувь нь өдөр тутам 30 минутаас дээш спортоор хичээллэж байна. | 20 | “Илүүдэл жингүй эртэч Монгол” аянаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 18 мянга гаруй иргэд тогтмол оролцон 129 иргэн жингийн илүүдлээс салсан байна. Аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллагын дунд спортын 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 3400 гаруй оролцогчид хамрагдсан. Мөн “Эртэч Дорнодчууд” бүх нийтийн хөдөлгөөн арга хэмжээг 6, 7, 8 дугаар сард зохион байгуулсан. Хөдөлгөөнд “Дорнод аймгийн дугуйн холбоо”, “Дорнод Найрамдал Зумба”, Хэрлэн сумын 7 дугаар багийн “Хийн дасгал” клубийн хамт олон болон төрийн байгууллагын албан хаагчид, нийт 150 иргэнийг хамруулсан. Монголын бүх ард түмний XV наадмын анхан шатны тэмцээнийг Дорнод аймагт спортын 6 төрлөөр зохион байгуулж, нийт 740 гаруй тамирчид оролцсон. Аймаг, орон нутгаас баг, тамирчдын зардалд 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн аварга шалгаруулах 14 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 1892 гаруй тамирчид оролцов. Дорнод аймгийн хөдөөгийн сумдын залуучуудын урлаг, спортын V дугаар бага наадам олон төрөлт (волейбол, олс таталт, үндэсний бөх, буриад сурын харваа, мини хөлбөмбөг, марш гүйлт) зохион байгуулагдаж, 13 сумын 273 тамирчид өрсөлдсөн. “Хуримтлалтай Дорнодчууд 2022” бүх нийтийн гүйлтэд 320 тамирчид оролцсон. “Алхангаа ярилцъя” аянаар салбар дундын оролцоог идэвхжүүлэн хөдөлгөөн дасгалын чеөенж зарлан салбарын хэмжээнд “Уухай” бүжгийн хөдөлгөөнт дасгалыг хийж, иргэдэд сурталчилсан. Дасгал хөдөлгөөний ач холбогдол сэдэвт сургалтыг төрийн 12 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын 350 албан хаагчдад зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд өглөөний алхалтаар 589 иргэн, бүжгийн таван клубийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 1678 иргэн тогтмол хичээллэж, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоо өнгөрсөн оныхоос 5,6 дахин нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээ батлагдаж, аймгийн эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх 5 зорилт бүхий 43 заалт арга хэмжээний төлөвлөгөөг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | |
| 41 | | 3.2.9 | Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлнэ. | хувь | Тэмцээнд оролцсон тамирчдын медаль авсан хувь. | Улс, бүс, нэрэмжит тэмцээнд оролцсон тамирчдын 29.3 хувь нь медаль авсан. | Дэлхий, Ази тив, улсын тэмцээнээс авах медаль 40 хувьд хүргэх. | Дорнод аймгаа төлөөлөн баг, тамирчид 5 удаагийн спортын наадам, 25 удаагийн улсын аварга, 6 удаагийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 700 гаруй тамирчин оролцож, 80 алт, 76 мөнгө, 103 хүрэл нийт 259 медаль хүртэж, тэмцээнд оролцогдын 38 хувь нь медалийн болзол хангасан. Аймгийн аварга шалгаруулах 15 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 1892 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд оролцсон тамирчдын зам, байр, хоолны зардалд орон нутгийн төсвийн хөрөнгөөс 41,0 сая төгрөг зарцуулагдсан. | 100 |
| Монгол хүний удмын сан | | | | | | | | | |
| 42 | Зорилт | 3.3 | Хүн амын эрүүл мэнд, удмын сан, тогтвортой өсөлт хадгалагдаж, хамгаалагдсан нөхцөл байдлыг бүрдүүлнэ. | хувь | Угийн бичиг хөтөлдөг өрх | 20 | 40 | Дорнод аймаг 24000 өрхтэй бөгөөд 4800 буюу 20 хувь нь угийн бичиг хөтөлж байна. Угийн бичиг хөтөлж, ургийн хэлхээгээ өвлөн уламжлуулах соёлд хэвшүүлэх замаар 2025 онд нийт өрхийн 40 хувьд хүргэх зорилтыг аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэлд дэвшүүлэн ажиллаж байна. | 100 |
| 43 | Арга хэмжээ | 3.3.1 | Өрх бүрийг “Угийн бичиг”-ээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ өвлөн уламжлах | Тоо | Хэрэгжүүлсэн төсөл, | 2 | 5 | 1.“Угийн бичиг” хэн сайн хөтлөх вэ? аяныг Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 9 багш, Онон-Улз сав | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | соёлд хэвшүүлнэ. | | арга хэмжээний тоо | | | газрын захиргааны 7 албан хаагчдад “Угийн бичиг хөтлөх арга зүй, хөтөлсний ач холбогдол” сургалт зохион байгуулсан. Аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Удмаа мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчинтай адил” 9 үеэ нэрлэх тэмцээн зохион байгуулснаар хүүхдүүд эцэг эхээсээ асуух, эцэг эх нь удам угсаагаа судалж, мэдэх, угийн бичгээ хөтөлж эхлэх сэдлийг авсан үр дүнтэй тэмцээн болсон. Энэхүү тэмцээний үр дүнд 3 өрх угийн бичгээ хөтөлж эхэлсэн.<br>2.Сумын ахмадуудтай “Угийн бичиг” хөтлөлтийг нэмэгдүүлэх ач холбогдлыг нь иргэдэд ойлгуулах талаар санал бодлоо солилцон ажиллаж байна.<br>3.Чойбалсан сумын соёлын төвөөс Угийн бичиг хөтлөх аргачлал сургалтыг 6-8 дугаар ангийн сурагчид болон ахмадуудын дунд зохион байгуулж, 69 хүн хамрагдсан. 4.Чулуунхороот сум “Удам судраа мэдэж, угийн бичгээ хөтөлцгөөе” уриан дор Угийн бичиг хөтлөх анхан шатны мэдэгдэхүүн олгох зорилгоор айл өрхөөр явж угийн бичгийг хөтлөх аргачлалыг зааж өгч сурталчлан ажилласан.<br>5.Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан залуу хойч үеэ угийн бичиг хөтлөх аргад суралцуулах, ач холбогдлыг тайлбарлан таниулах зорилготой “Угийн бичиг”-ийн сургалтад Угийн бичгийн талаарх мэдээллийг өгсөн. | |
| 44 | | 3.3.2 | Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлж, хүн амын удмын сан, нөхөн үржихүйг | түвшин<br><br>түвшин тоо | Амьгүй төрөлт | 4,7 | 3,0 | Нялхсын эндэгдэл 12 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 9,3 болж өнгөрсөн оны мөн үеэс 0,6 промилиор нэмэгдсэн байна. Амьгүй төрөлт 9 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 төрөлтөд 6,9 промиль болж, өмнөх оныхоос 2,4 промилиор буурсан. Төрөлхийн гажигтай | 0 |
| | | | | | Нярайн эрт | 2,6 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамгаална. | | үеийн эндэгдэл | | 2,0 | төрсөн хүүхэд 24 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 2 тохиолдлоор буурсан. | |
| | | | | | Төрөлхийн гажигтай хүүхэд | 13 | 2 дахин бууруулна | | |
| Гэр бүл | | | | | | | | | |
| 45 | Зорилт | 3.4 | Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжиж, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлнэ. | тоо | Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлсэн нийгмийн үйлчилгээ | 115 | 480 | “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-гээр 13 сумдын 976 (хүүхэд 434, эр 270, эм 167, насанд хүрэгчид 542, эр 202, эм 340) иргэдэд зөвлөгөө, сургалт хийж, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлж, шийдвэрлэх зэрэг олон талын нийгмийн үйлчилгээг үзүүлсэн. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” төв, “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр нийт 192 (насанд хүрэгч 62, хүүхэд 131) хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, оношилгоо, дүгнэлт, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн. Хүүхэд хамгааллаар магадлан итгэмжлэгдсэн “Анна хоме” асрамжийн төвд 25, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Хүүхэд хөгжил” төвд 15, хүүхэд харах 5 төвд 70, нийт 110 хүүхэд төвүүдээр дамжуулан нийгэм хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байна. Зорилтот 270 өрхийн 200 хүүхдийг эрсдэлийн даатгалд, 25 хүүхдэд хичээлийн хэрэглэл, 1810 хүн гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдсан. Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлсэн нийгмийн үйлчилгээнд нийт 1478 (насанд хүрэгч 604, хүүхэд 874) иргэн хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 32,4 хувиар өссөн. | 100 |
| 46 | Арга хэмжээ | 3.4.1. | Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаанд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | тоо | Боловсруулж хэрэгжүүлсэн хөтөлбөр | 5 | 6 | 1.Гэр бүл, хүүхэд, залуучуудын мэдээллийн санд суурилсан хүн амын бүлгүүдэд чиглэсэн Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр,<br>2.Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр,<br>3.Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр,<br>4.Оюутны хөгжлийн хөтөлбөр,<br>5.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөтөлбөр зэрэг нийт 5 хөтөлбөр хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийт 122 төрлийн үйл ажиллагаанд 105466 хүн (эр 73135, эм 56716) хамрагдсан. | |
| 47 | | 3.4.2 | Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | 01 | Хүүхдийн ордонтой болсон эсэх | 0 | 1 | “Хүүхэд хөгжлийн ордон” байгуулах тооцоо судалгааг хийж, зураг төсөв боловсруулах 150,0 сая төгрөгийг Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлсэн. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Дорнын бүжиг”, “Үүлэн балет”, Шинэ суваг телевизийн дэргэдэх “Хүүхдийн цаг” нэвтрүүлэг, “А&О” хүүхдийн драмын дугуйлан зэрэг 22 байгууллагын дэргэдэх 60 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 5600 гаруй хүүхэд суралцаж байна. Мөн Улсын хэмжээнд болон орон нутагт зохион байгуулагдсан 12 төрлийн уралдаан, тэмцээнд 10000 гаруй хүүхэд оролцож, авьяас, ур чадвараа хөгжүүлсэн. 2022 онд нийт 18000 хүүхэд хамрагдсан нь өмнө онтой харьцуулахад 54,4 хувиар өссөн байна. Хүүхдийн авьяас хөгжлийг дэмжих чиглэлээр тооцоо, судалгаа хийж, “Хүн болох багаасаа” төсөл боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаад байна. | 30 |
| 48 | | 3.4.3 | Гэр бүл, хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлт, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | хувь | Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт | 22.1 | 18.1 | “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 48 үүнээс хүүхэд 33 (эр 12, эм 21) насанд хүрэгч 15 эмэгтэйг төвд 780 хоног байрлуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, 7 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. Өмнөх онтой харьцуулахад хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 26,1 хувиар буурсан. “Хүчирхийлэлгүй хүүхэд”, “Анхаарч хамгаалъя”, “Хүүхэд эрхэм хэрэглэгч” 3 төрлийн аяны хүрээнд 1150 багш ажилчдад, 3653 эцэг эх, 4786 хүүхдэд хөдөлмөр эрхлэлт, хорт зуршил, гэмт хэрэг зөрчлөөр сургалт хийж, сургуулиудад зөвлөмж өгч, эрсдэлээс | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | урьдчилан сэргийлсэн. Хүүхдийн эрх зөрчигдсөн 134 утасны дуудлага, 71 өргөдөл, гомдол бичгээр хүлээн авч, 208 хүүхдэд шуурхай тусламж, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, 110 хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зөрчлийг шийдвэрлэж, нийт 318 (эр 135, эм 183) хүүхдийн зөрчигдсөн эрхийг хангаж ажилласан нь өмнө онтой харьцуулахад дуудлага, мэдээлэл 32 тохиолдлоор буурч шийдвэрлэлт 98% байна. | |
| 49 | | 3.4.4 | Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох замаар жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллана. | хувь | Хөтөлбөр хэрэгжилт | 70 | 100 | Аян хүрээнд нийт жендерийн эрх тэгш байдлыг хангах агуулга бүхий 12 удаагийн пост, мэдээллийг орон нутгийн цахим хуудас, ТВ-6 телевизээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн. Үүнээс багийн гишүүд өөрсдийн цахим ном болон хариуцан ажилладаг мэдээллийн сайт, хуудас, бүлгүүдтэй хуваалцан иргэдэд жендерийн талаарх мэдээллийг 13635 хүнд түгээсэн. | 100 |
| 50 | | 3.4.5. | Хүмүүнлэгийн байгууллагын иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийнэ. | 0<br>1 | тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэл хийсэн эсэх | 0 | 1 | Аймгийн Орон нутгийн төсвөөс 20,0 сая, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг Үндэсний хүмүүнлэгийн байгууллагаас 17 сая, нийт 37,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Улаан загалмайн хороонд ОХУ-д үйлдвэрлэгдсэн УАЗ-Фургон автомашиныг 2021 онд худалдан авч өгсөн. | 100 |
| Хүнд ээлтэй амьдрах орчин | | | | | | | | | |
| 51 | Зорилт | 3.5 | Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, аюулгүй, тухтай, таатай орчныг бүрдүүлнэ. | хувь | Норм дүрэм, стандартын хэрэгжилт | 50 | 50-аас доошгүй | Шинэ төлөвлөлтийн хүрээнд баригдаж байгаа орон сууцны хотхон, бүтээн байгуулалтын ажлуудын загвар зураг /эскиз/-т "Хот байгуулалтын тухай" хууль, Хот тосгоны барилгажилтын норм БНБД 30-01-04 болон бусад норм дүрмийн дагуу иргэдийн эрүүл, аюулгүй зорчих таатай орчныг бүрдүүлэх төлөвлөлт хийх чиглэлийг өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Мөн орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тохижилт, орон сууцны дулаалга, гадна фасад, дээврийн засварын ажлуудад норм стандартыг хангуулахад хяналт тавьж ажиллаж байна. | |
| 52 | Арга хэмжээ | 3.5.1 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхыг нэмэгдүүлж хүнсний аюулгүй байдалд тавих хяналт шалгалтыг сайжруулна. | тоо | Хяналт шалгалтын тоо | 150 | 200 | Лабораторийн шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүний (хүнсний бүтээгдэхүүн, ахуйн бүтээгдэхүүн, орчны шинжилгээ) 565 сорьцод 2249 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийгдсэн. | 70 |
| | | | | тоо | Лабораторийн шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүний сорьцын дээжийн тоо | 1950 | 2100 | | |
| 53 | | 3.5.2 | Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдүүлж ажиллана. | хувь | Норм дүрэм, стандартын хэрэгжилт | 50 | 50-аас доошгүй | Шинээр төлөвлөгдөн баригдаж байгаа орон сууцны хотхоны загвар зураг /эскиз/-т “Хот байгуулалтын тухай” хууль, Хот тосгоны барилгажилтын норм БНБД 30-01-04 болон бусад норм дүрмийн дагуу шинээр барих хотхон хороололд барилгажилтыг нийт газрын 70 хувьд хийх, үлдэх 30 хувьд ногоон байгууламж бүхий авто зогсоолыг төлөвлөх чиглэлийг аж ахуйн нэгжүүдэд өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тайлант онд Хэрлэн суманд иргэн Сайнбаярын 405 айлын, иргэн Энх-Эрдэнийн 54 айлын, иргэн Амартүвшингийн 64 айлын орон сууцны хорооллын зурагт орчны тохижилтыг бүрэн тусгаж өгсөн. | 100 |
| 54 | | 3.5.3 | Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ. | Га | Ногоон байгууламжийн хэмжээ | 61.2 | 70 | Бүх нийтээр мод тарих өдөр буюу 5 дугаар сарын 07-ны өдөр Чойбалсан хотын Найрамдал парк, Өүлэн эхийн хөшөөний цэцэрлэгт хүрээлэн, Нисэхийн зам дагуу байгуулсан ойн зурвас бусад нийтийн эзэмшлийн гудамж | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | талбайд нийт 30 орчим төрийн байгууллага, аж ахуй нэгжүүд мод тарих ажилд идэвхтэй оролцлоо. Уг ажлын хүрээнд 92 байгууллагын 1800 ажилтан, албан хаагч, 14 аж ахуйн нэгжийн 233 ажилтан, 28 өрхийн 84 иргэн, 18 сургууль, цэцэрлэгүүд нийт 3317 иргэн хамрагдаж 10 гаруй нэр төрлийн 34187 ширхэг мод тариад байна. | |
| 55 | | 3.5.4 | Аймгийн төв, сум, суурин газарт үерийн далан суваг, борооны болон хөрсний ус цуглуулан зайлуулах байгууламж барина. | км | Шинээр баригдах үерийн далан суваг, ус зайлуулах шугамын урт | 3.1 | 6.5 | Аймгийн төвийн гадаргуугийн усыг цуглуулан зайлуулах шугам хоолой барих ажлын зураг төсвийг аймгийн 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр боловсруулсан. Барилга угсралтын ажлын хөрөнгийг 2022 оны улсын төсөвт тусган батлуулах саналыг Сангийн яам, БХБГазарт хүргүүлсэн. Одоогоор дээрх зураг төсөвт тусгагдсан ажлын 3 дугаар хэсэг болох Читийн гудамжны ус зайлуулах шугам хоолойг Читийн гудамжны авто замыг шинэчлэх ажлын хүрээнд гүйцэтгэхээр “Авто агро” ХХК гэрээ байгуулан ажиллаж байгаа ба ус зайлуулах ф600 диаметртэй шугам хоолойг суурилуулах ажил хийгдэж байна. Мөн энэ онд “Хэрлэнгийн гудамжийг үерийн уснаас хамгаалах далан барих /Хэрлэн сум, 2 дугаар баг/” ажилд "Талын хас констракшн” ХХК шалгаран гэрээ байгуулаад байна. | 70 |
| 56 | | 3.5.5 | Аймаг, сумын төв дотор хатуу хучилттай авто зам, явган хүний, дугуйн зам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | км | Хатуу хучилттай автозамын урт | 41.4 | 50 | Аймгийн 2021 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах Хэрлэн сумын 4 дүгээр баг, Гандангийн гудамжны 100 м, Найрамдал цэцэрлэгт хүрээлэнгийн авто зогсоолын 160 м хатуу хучилттай авто замын дагуу 1,5-2,0 м өргөн явган хүний зам барьж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч хавтанг стандартын дагуу хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээн аваад байна.<br>Дашбалбар сумын төвд 1,5 км, Баяндун сумын төвд 440 м хатуу хучилттай зам сумын ОНХС- | 70 |
| | | | | км | Явган замын урт | 16 | 20 | | |
| | | | | км | Дугуйн замын урт | 1 | 21 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон.<br>Шинээр Хэрлэн сумын 6 дугаар баг Читийн гудамж дагуу “Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/”, Хэрлэн сумын 1 дүгээр багт “Илч” хорооллын гадна 660 м хатуу хучилттай авто зам болон 2 талаар явган хүний зам барих ажил өнгөрсөн оноос эхлэн хийгдэж байна.<br>Энэ онд Хэрлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт “Орон сууцны залуус хорооллын доторх хатуу хучилттай авто зам, 1.09 км /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр баг/” ажлыг стандартын дагуу хийхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Топ буянт зам” ХХК гэрээ байгуулаад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2022 онд 2 талаараа явган хүний болон явган хүний зам бүхийн 14м өргөн 5,5 км хатуу хучилтай авто зам баригдаж байна. | |
| 57 | | 3.5.6 | Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, хогны менежментийг сайжруулна. | тоо | Сургалт нөлөөллийн ажлын болон хамрагсдын тоо | 72<br><br>4767 | 110-аас дээш<br><br>5000-аас дээш | Агаарын орчны бохирдол, агаарын чанарын 45 мэдээ, мэдээлэл, жаран тв хамтран 3 төрлийн шторк бэлтгэн цахим нөлөөллийн ажлыг хийсэн бөгөөд хандалт тоо 25458 хүрээд байна. Хэрлэн сумын 100 айлын дулаан алдагдлыг хэмжин, агаарын бохирдлын талаарх сургалт зөвлөмжийг өгсөн. “Яндангаа хөөлье” аяны уриалга, шторкуудыг 2022 оны 1, 2 дугаар сард байгууллагын фейсбүүк “Дорнод аймаг байгаль орчин” хаяг болон пейж “Дорнод аймаг байгаль орчин, аялал, жуулчлалын газар”-ын цахим хуудсаар олон нийтэд сурталчилсан.<br>“Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хогийг эх үүсвэрт нь ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх” ажлын тендер 2 удаа зарлаад байна. | 70 |
| 58 | | 3.5.7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, | тоо | Арга хэмжээ | 1 | 2 | "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийн | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | хүрээнд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв” баригдаж эхэлсэн. Уг барилга нь 1800 мкв талбайтай бөгөөд 1.3 сая долларын санхүүжилтээр баригдаж байна. Барилгын дулаан, цахилгаан, бохирын шугамын ажил хийгдэж дууссан бөгөөд барилгын гадна талын пассат хийгдэхээр хүлээгдэж байна. Барилгын ажлын явц 70 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор дараалсан 5 сургалтад Дорнод аймгаас нийгмийн ажилтан 4 хүн, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчаар 2 хүн, АШИҮИС-н тэтгэлэг хөтөлбөрт 2 хүн , хэл засалчаар 4, сул харааны үнэлгээний сургалтад 1, нийт 13 хүнийг сургалтад хамруулсан. | |
| Хүн, нийгмийн аюулгүй байдал. | | | | | | | | | |
| 59 | Зорилт | 3.6 | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | хувь | Хуулийн хэрэгжилт | 87 | 93 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлах тухай”, Улсын Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр “Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын Шар түвшин”-д шилжүүлэх тухай тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 11 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд нийтийг хамарсан соёл урлаг, үзвэр үйлчилгээ, спортын арга хэмжээний хоригийг цуцалж, аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг хэвийн горимд шилжүүлж 00:00 цаг хүртэл ажиллахаар тогтоож хэрэгжилтийг хангах ажиллах чиглэлээр гудамж талбай олон нийтийн газруудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | Арга хэмжээ | 3.6.1 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрх зүйн сургалтыг иргэд, төрийн албан хаагчдад зохион байгуулна. | тоо | Эрх зүйн албан болон албан бус сургалт, сургалтад хамрагдах иргэдийн тоо | 30<br>3200 | 40<br>4500 | Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 75 албан хаагчдад шинэчлэгдсэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн сургалтыг 02 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулсан. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 04 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр 37 алба хаагч нарт сургалт зохион байгуулсан. Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар 04 дүгээр сарын 27-ны өдөр 28 алба хаагч нарт сургалт зохион байгуулсан. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн батлагдсантай холбоотой хуулийн сургалтыг 04 дүгээр сарын 29-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын 31 алба хаагч нарт зохион байгуулсан. Монгол Улсын Хилийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох журмын сургалтыг 05 дугаар сарын 18-ны өдөр 14 сумын Засаг даргын Тамгын газрын нийт давхардсан тоогоор 348 алба хаагч нарт сургалт зохион байгуулсан. Аймгийн 14 сумын Засаг даргын Тамгын газарт Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар 04 дүгээр сарын 27-ны өдөр 35 алба хаагч нарт сургалт зохион байгуулсан. Баянтүмэн сумын иргэдэд 05 дугаар сарын 28-ны өдөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 85 иргэдэд сургалт зохион байгуулсан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн сургалтыг 11 дүгээр сарын 28-ны өдөр 14 сумын 67 багийн Засаг дарга нарт сургалт | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зохион байгуулсан. Нийт давхардсан тоогоор 2227 алба хаагч, иргэд сургалтад хамрагдсан. Орон нутгийн Жаран ТВ-тэй хамтран Оюуны өмчийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн талаар мэдээллийг бэлтгэн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс иргэд олон нийтэд сурталчилсан. | |
| 61 | | 3.6.2 | Иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 39 | 42 | Иргэдийг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил, осолд өртөж хохирох /осгож, хөлдөх, хордлого/-оос урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Зөвийг зөвлөе” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийт 5 төрлийн сэрэмжлүүлэг, шторк, нэвтрүүлэг зэргийг орон нутгийн “TV-6”, “Мижи”, “Нутаг 21”, “Дорнод ТВ” зэрэг телевизүүд, Жаран.мн сайт болон “Дорнодчуудын нэгдэл”, “Дорнодын нэгдсэн зар”, “Дорнод Улаанбаатар явна ирнэ” зэрэг 73 группүүдээр 522349 иргэнд түгээлт хийж ажилласан. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоног бүр эрүү, хэв журмын нөхцөл байдал болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар D1, Дорнод, ТВ-6, Мижи, Шинэ суваг зэрэг орон нутгийн телевизүүдээр мэдээлэл хийсэн. Гудамж талбайд байрлах электрон дэлгэц, самбаруудад хулгайн гэмт хэрэг, залилан мэхлэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, замын хөдөлгөөний | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг, постер, шторкыг давхардсан тоогоор 64 телевиз, 38 сайт, 228 цахим хуудсанд байршуулж давхардсан тоогоор нийт 84495 иргэдэд хүргэж, 4 лед дэлгэц, самбарт байршуулан аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран “Шүр” захаар хяналт шалгалтыг зохион байгуулсан. | |
| 62 | | 3.6.3 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | тоо | Зохион байгуулсан арга хэмжээ | 0 | 10 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 1,500,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 05/06 дугаар зөвлөмжийн 1.6, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ажиллаж байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн 1, хувийн хэвшлийн 6, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн 16 байгууллага, Баян-уул, Дашбалбар, Халхгол сумдад сум дундын эмнэлэг, хилийн цэргийн хүн эмнэлгийн алба 3 байгууллагуудаас мансууруулах сэтгэцэд нөлөөт эм худалдах зөвшөөрөлтэй эмийн сан, хувийн хэвшлийн эмийн сангуудыг судалгааг авсан. Тайлант хугацаанд БОЭТ-ийн СЭМТасагт 34 иргэн бүртгэл судалгаанд авагдсанаас сэтгэцэд нөлөөт эм тогтмол хэрэглэдэг 202 иргэнд Сэтгэцийн эрүүл мэндийн тасгийн эрхлэгч эмчийн зөвшөөрлөөр өвчний байдлаас нь шалтгаалан амитриптилин, седуксин, галоперидол, тизерцин, аминазин, карбамазепин эм болон тариагаар модетин | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | депо зэргийг үнэгүй сар бүр олгож байна. Мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон Баян-Уул сумын 6-р багийн нутаг, Ульхан хилийн боомт, Эрээн даваа, Онон голын урд тал хуучин ферм байсан суурь, иргэдийн малын өвөлжөөний хашаа, бууц, ойн зах, царам гэх газруудад нийт 1.7 га талбайд, Халх голын сумын төвөөс баруун урд зүгт 300 метр зайд 2 км-ийн радиуст 6.3 га талбайд, сумын 4-р багийн нутаг Хар ямаат гэх газарт, аймгийн төвөөс газрын тосны 19 дүгээр талбай явах зам дагуу баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон 1.3 га талбайд устгал хийхээр төлөвлөн, газрын байршил, талбайн хэмжээг жагсаалтаар гаргасан. Зэрлэг олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон бүс нутаг нь хилийн хориотой бүсэд оршдог бөгөөд устгалын ажилд хүн, хүч татан оролцуулах чиглэлээр Хилийн 0132, 0198, 0275 дугаар ангиудтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд устгалын ажилд татан оролцуулахаар тусгасан. Аймгийн Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт 03 дугаар сарын 19-ний өдөр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг харуулсан тараах материал, зурагт хуудас, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах багаж, илрүүлэгч тест зэргийг дэлгэн үзүүлж мансууруулах бодисын хор уршгийн талаар товч мэдээллийг иргэдэд хүргэсэн. | |
| 63 | | 3.6.4 | Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх ”Албадан эмчилгээний төв” байгуулах ажлыг зохион байгуулна. | хувь | ”Албадан эмчилгээний төв” байгуулсан эсэх | 0 | 1 | Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх ”Албадан эмчилгээний төв” байгуулсан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | | 3.6.5 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн малын бүлэг холбоодыг байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 9 | 10 | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг хүрээнд 13,500,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, хэрэг бүртгэлийн хэргүүдийг шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/138 дугаар “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Аймаг болон Улсын хэмжээнд малын хулгайн гэмт хэрэг үйлдсэн оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүд болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтний судалгааг гаргаж гарын авлага бэлтгэсэн. Нийт сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мал, мах худалдан авах хувь хүн, аж ахуй нэгж байгууллагууд стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар хамтарсан шалгалтыг зохион байгуулсан. Аймгийн Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, бүх сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар нийт 160 гаруй алба хаагч нарыг оролцуулан 03 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зөвлөгөөн зохион байгуулан холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлэн, хамтарч ажиллах чиглэлээр мэдээлэл солилцож ажиллав. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зурагт самбарыг аймгийн төвөөс орох, гарах төв зам дагуу байрлах Ялалт, Баянтүмэн гүүрний /10х12/ самбаруудад аннос байршуулсан. Аймгийн Хөгжимт драмын театрын найруулагч, жүжигчидтэй хамтран 2 шторк, контент нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | "Мижи", "Дорнод ТВ", "Шинэ суваг", "Жаран.мн" хэвлэл мэдээллийн байгууллагуудаар иргэдэд хүргэсэн. "Хулгайч нарт боломж бүү олго", "Малчин таны хариуцлага хамгийн чухал", "Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авч байна", "Эрдэнэт болсон мал сүргээ эзэнгүй бүү орхи", "Малын хулгайн ял шийтгэл чангарлаа" зэрэг 2500 ширхэг брошур зурагт хуудсыг бэлтгэн малчин болон мал бүхий иргэдэд түгээж, олон нийтийн цахим хуудсанд бэлтгэсэн мэдээллийг хүргэсэн. | |
| 65 | | 3.6.6 | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн жолооч, зорчигч нарт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 12 | 13 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар "Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10,000,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Удирдамж, төлөвлөгөөний дагуу 2021 онд зохион байгуулсан ажлын танилцуулга, гарсан гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан нөхцөл, хүрсэн үр дүнгийн талаарх криминологи судалгааны танилцуулгыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Гудамж замын хяналт шалгалтаар 5151 зөрчил илрүүлэн ажилласнаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 421, эрхийн үнэмлэхгүй болон эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 58, нийт түр саатуулах үндэслэлээр 459 тээврийн хэрэгслийг түр саатуулж, замын хөдөлгөөний хууль, дүрмийг бусад байдлаар зөрчсөн 4657 жолоочид 126,267.5 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулан 64 жолоочийн эрхийг хасаж 22 жолоочийг шүүгчийн шийтгэврээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулан шийтгэлийн хуудсаар 363 жолоочийн жолоодох эрхийг тус | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүр 1 жилээр хасаж 363 жолоочийг 145.200.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан. Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Уусан бүү жолоод”, “Өвлийн дугуй”, “Тусгай дуут дохио” “DON’T DRINK AND DRIVE “ “Шөнийн сурвалжилга” “Гар утас” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. “Гар утас” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 500 ширхэг санамж сэрэмжлүүлэг хуудас бэлтгэн иргэдэд хүргэсэн. Улсын чанартай хатуу хучилттай А/0502 дугаарын авто замд Баянтүмэн сумын чиглэлд байнгын эргүүл 1, Булган сумын чиглэлд хөдөлгөөнт эргүүл 1, Хөлөнбуйр сумын чиглэлд байнгын хяналтын пост 1, хөдөлгөөнт эргүүл 1, тус тус хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллуулснаар магистрал замд зам тээврийн гэмт хэрэг, осол бүртгэгдээгүй байна. | |
| 66 | | 3.6.7 | Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлнэ. | тоо | Үйлчилгээ авсан иргэдийн тоо | 400 | 500 | Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Дорнод аймаг дахь хууль зүйн туслалцааны төв нь Дорнод аймаг дахь Өмгөөлөгчдийн зөвлөлийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Улсын өмгөөлөгч нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 106 сэжигтэн, яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 501 иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлсэн. | 100 |
| 67 | | 3.6.8 | Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, бусад төрлийн гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг сайжруулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 5 | 7 | Аймгийн хэмжээнд “Насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 12-ны өдөр багийн засаг дарга, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхийн төлөөлөл нийт 500 алба хаагч, иргэд олон нийтийг хамруулсан. Жендерийн хүчирхийллийн эсрэг “Жаргалтай гэр бүл” арга | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэмжээний хүрээнд 20 шторк, постер, подкаст, видеог фейсбүүк пейж болон олон хандагчтай 25-40 цахим хуудсанд түгээсэн. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 төрлийн сэрэмжлүүлэг постерыг орон сууцны хорооллын орц, төмөр зам, хүнсний дэлгүүрүүдэд болон орон нутгийн Лайф, Улз, Дорнын ундарга цэвэр усны компаниудтай хамтран цэвэр усны савны гадна байршуулсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу шүүхийн шийтгэврээр баривчлагдсан хүмүүст “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай” хуулиуд болон “Архи тамхины хор нөлөө”, “Гэр бүлийн хүчирхийлэл түүний шинж”, “Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг”, “Хүчирхийллийг үл тэвчих”, “Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал”, “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх” сэдэвт сургалтад нийт 138 иргэнийг хамруулсан. “Хүүхэд хамгаалал” арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд байгаа, хараа хяналтгүй хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Нийтийн аж ахуйн харьяа усан сангийн 43 түгээгч ажилтан, дэлгүүрийн худалдагч 92 иргэн, хөрш айл 41 иргэн, байрны жижүүрээр ажилладаг 36 иргэдтэй уулзаж санал хүсэлтийг авч гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдлийн талаар холбогдох газарт дуудлага мэдээлэл өгч иргэний мэдээлэх үүргээ биелүүлэх талаар зөвлөмж өгч хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд эрсдэлд нөхцөлд байгаа хараа хяналтгүй, хүчирхийлэл өртөж болзошгүй 13 хүүхдийг илрүүлж хамтарсан багт шилжүүлэн, арга хэмжээ тооцуулахаар 5 эцэг, эх асран | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамгаалагчийн кейсийг шилжүүлсэн. | |
| 68 | | 3.6.9 | Хүний эрхийг хамгаалах ажлыг зохион байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 0 | 5 | Хүний эрхийн Үндэсний Комисс Дорнод аймагт цахим хуудсаар дамжуулан хүний эрхийн талаарх мэдээлэл, цуврал постер, шторк бүхий нийт 133 мэдээ байршуулан сурталчлан ажиллав. Дорнод Хэнтий, Сүхбаатар аймгийн Шүүхийн захиргааны ажилтнуудад 04 дүгээр сарын 11-ны өдөр “Жендер ба хүний эрх” сэдвээр 45 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Аймгийн Цагдаагийн газарт 04 дүгээр сарын 12-ны өдөр “Жендер ба хүний эрх” сэдвээр 120 албан хаагчдад сургалтад хамруулсан. Сургалт зохион байгуулснаар жендерийн тухай, ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамт, гомдол хаана гаргах, хэрхэн шийдвэрлэдэг талаарх мэдээллийг алба хаагчдад тодорхой ойлголттой болсон. Монголын Хуульчдын холбоооноос жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг "Хуульчийн Про Боно өдөр" болгон зохион байгуулдаг билээ. Аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Хуульчийн Про Боно өдөр 2022” өдөрлөгт аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүхийн Тамгын газар, Цагдаагийн газар, Прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комиссын Дорнод аймаг дахь референт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Өмгөөлөгчдийн салбар зөвлөл, Нотариатчидын танхимын салбар, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагууд хамтран аймгийн Тусгаар тогтнолын талбайд байгууллагын үйл ажиллагаа сурталчлах, танилцуулга хийж, хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээг үнэ төлбөргүй зохион байгуулж иргэдэд 6 ном, гарын авлага, 4 сэтгүүлийг түгээн хүргэсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | | 3.6.10 | Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 2 | 5 | Аймгийн 14 сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, 25 агентлагийн эрх бүхий албан тушаалтанд 01 дүгээр сарын 07-ны өдөр ХАСХОМ бүрдүүлэлттэй холбогдуулан 39 албан хаагчдад цахим сургалт зохион байгуулсан. Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвээр 02 дугаар сарын 21-ны өдөр 75 албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймаг, сумын албан тушаалтнуудад зориулан давтан сургалтад 02 дугаар сарын 22-ны өдөр 14 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлагийн нийт 18 албан хаагчдын сургалтад хамруулсан. Мөн тус газраас зохион байгуулсан 02 дугаар сарын 23-ны өдөр 21 аймгийн удирдах болон ахлах ажилтны давтан сургалт, 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг анхан шатны сургалтад 14 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлагийн 120 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Гадаадын иргэн харьяатын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт аймгийн авлигын эсрэг нөхцөл байдал, ашиг сонирхлын зөрчлийн тухай сэдвээр 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл нийт 140 алба хаагч нарт сургалт зохион байгуулсан.Нийт 392 алба хаагч сургалтад хамрагдсан. Аймгийн Засаг даргын Тамгын газарт аймгийн 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3-т заасан Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулахаар самбар бэлтгэсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | | 3.6.11 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, өргөдөл гомдлыг хүлээн авах, хяналт шалгалтыг зохион байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 7 | 10 | ШӨХТГ-ын орон нутаг дахь улсын байцаагч 2022 оны 10 дугаар сард томилогдсоноос хойш “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийг олон нийтэд сурталчлах, мэдээлэл хүргэх цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж 14 сумын Засаг дарга, 67 багийн Засаг дарга нар болон сумдын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, эрх зүйн хөтөч нарын нийт 109 албан хаагчийг хамруулсан байна. Тус сургалтын хүрээнд сумдын эрх зүйн хөтөч нар ШӨХТГ-т гомдол гаргах, орон нутгийн байцаагчид хэрхэн хандах талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн видео танилцуулга бэлтгэн Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 25 агентлагт хүргэж ажилласан. Тус танилцуулгыг албан байгууллагууд мэдээллийн цаг, дотоод хурлаараа дамжуулан ажилтан, албан хаагчдадаа хүргэж нийт 1000 орчим хүнд хүргэгдээд байна. | 100 |
| 71 | | 3.6.12 | Кибер гэмт хэрэг, кибер хандлагатай тэмцэх ажлыг зохион байгуулна. | тоо | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 2 | 3 | “Админ” арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээний фейсбүүк группийн админуудыг судалгаанд авч хамтран ажиллах талаар сургалт орсон. Аймгийн хэмжээнд цахим тоглоомын үйл ажиллагаа явуулж байгаа газруудад хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулсан. Хууль зүй дотоод хэргийн яам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр Дорнод аймагт хэрэгжүүлж буй “Эерэг, эрүүл нийгэм-бидний ирээдүй” төслийг хэрэгжүүлэн аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, эцэг эх, их дээд сургуулийн оюутан нарт цахим хэрэглээний зөв дадалд сургах, түүний хор хөнөөл, цахим гэмт хэргийн талаар ойлголт, урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2-3 өртөө болгон семинар зохион байгуулж ажилласан. Аймгийн гэмт хэргээс урьдчилан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Цахим гэмт хэрэг түүний хор аюулаас урьдчилан сэргийлэх нь” гарын авлага бэлтгэж ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, их дээд сургуулийн оюутан сурагчдад тараасан. “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт шторкийг орон нутгийн телевизүүдээр өдөрт 4-5 удаагийн давтамжтайгаар явуулж иргэдэд мэдээлэл хийж ажилласан. | |
| 72 | | 3.6.13 | Гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн гамшгийн эрсдэлийн удирдлагын бүтцийг бэхжүүлнэ. | хувь | Гамшгаас хамгаалах чадавх | 35 | 70 | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 80 дугаар тогтоолоор “22 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж” 2022 оны гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан. Гамшгийн эрсдэлийг бууруулах зардалд 139,940,000 төгрөгийг шийдвэрлүүлж, батлуулан орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна. ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Гамшигт тэсвэртэй орон нутаг төсөл”, МУ-ын Улаан загалмайн нийгэмлэг хамтран “Бүсийн төвийн удирдах бүрэлдэхүүний гамшиг, Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний сургалт”-д аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 22 гишүүдийг хамруулан Гамшиг, онцгой байдал үүссэн нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авах, ослын үеийн удирдлагын системийг нэвтрүүлэх, гамшгийн үед олон улсад дагаж мөрддөг баримт бичгүүдийн талаар ойлголт өгөх, гамшигтай тэмцэх бэлэн байдлыг хангуулах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх үйл ажиллагаа сэдвээр 3 өдрийн танхимын болон хээрийн дадлага сургалт зохион байгуулж удирдлагыг чадавхжуулсан. | 90 |
| | | | | тоо | Арга хэмжээний тоо | 5 | 30 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 73 | | 3.6.14 | Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, гамшгийн онцгой нөхцөлийн үед шаардагдах тоног төхөөрөмж, бараа материалын нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж нөөцийг бүрдүүлэн, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | тоо | Агуулахын тоо | 1 | 2 | Дэлхийн Зөн Монгол ОУБайгууллага “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслөөс 2022 онд 43 нэр төрлийн 276 ширхэг 30,306,340,91 төгрөгийн өртөг бүхий багаж хэрэгсэл, үзүүлэн самбар, сургалтын хэрэглэгдэхүүн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг сайжруулах чиглэлээр Эрэн хайх, аврах ангид Гүний шумбалтын иж бүрэн өмсгөл -15,400,000 төгрөг, Онцгой байдлын газрын шуурхай албаны автомашинд шаардлагатай механик ажиллагаатай татлага /лебедка/ 4,600,000 төгрөг, Онцгой байдлын газрын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх завины мотор 2 ширхэг-17,785,554 төгрөг, Онцгой байдлын газрын анги салбаруудын ариутгал татуургын хоёрдогч бохирдлыг цэвэрлэх, хаягдал бохир ус соруулах автомашины зардалд 5,000,000 төгрөг, сумдын мэргэжлийн анги болон Онцгой байдлын газрын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор ой, хээрийн түймэр унтраах үлээгч аппарат 60 ширхгийг авах зардал 52,800,000 төгрөг нийт 139,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. ОБЕГ-аас 39 нэр төрлийн 2370 ширхэг нийт 149,837,797 төгрөгийн өртөгтэй нормын хувцас, 4 нэр төрлийн 30 ширхэг автомашины дугуйнууд, 28 нэр төрлийн 945 ш 49,604,150 төгрөгийн өртөг бүхий аврах ажиллагааны багаж, тоног төхөөрөмж, 128,843,000 төгрөгийн үнэ бүхий шуурхай албаны автомашин /ниссан патрол Y61/ тус тус шийдвэрлэж гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тоног төхөөрөмжийн нэр төрөл тоог нэмэгдүүлэн ашиглалт, хадгалалт дээр анхаарч ажиллаж байна. | 90 |
| | | | | тоо тн | Нөөцийн бараа материалын нэр төрөл, хэмжээ | 12<br>100 | 50 хувиар нэмэгдүүлэх | | |
| | | | | тоо | Тоног төхөөрөмжийн нэр төрөл, хэмжээ | 1<br>30 | 10<br>50 | | |
| 74 | | 3.6.15 | Ой хээрийн гал түймэр гарах, тархан дэлгэрэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор түймрийн эрсдэл | км | Шинээр байгуулсан болон сэргээн | 373 | 623 | Монгол Улс, ОХУ-ын хилийн дагуу түймрээс хамгаалах цурав татах ажил байгаль, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тухайлбал цурав татахаар төлөвлөж байсан | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүхий газарт шороон болон халз зурвас байгуулан хавар, намрын улиралд сэргээн сайжруулах ажлыг зохион байгуулна. | | засварласан шороон зурвасын урт | | | Баян-уул, Баяндун Дашбалбар сумдад 10 дугаар сард хур тунадас, нойтон цас их хэмжээгээр орсны улмаас цурав татах үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэнээс дээрх ажил хийгдээгүй байна. | |
| 75 | | 3.6.16 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, эрт зарлан мэдээлэх системийг сайжруулна. | хувь<br>тоо | Төслийн хэрэгжилт | 0<br>3 | 30<br>8-аас доошгүй | Онцгой байдлын ерөнхий газар болон Азийн хөгжлийн банктай хамтран “Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн хүрээнд Чойбалсан хотын 4 байрлалд зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхагийг байгуулахаар саналыг хүргүүлж ажилласан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны ЗГ-2/593 дугаар албан бичиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 10/09 дугаар зөвлөмж, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн хуралдааны шийдвэр “Аймаг, нийслэл, сумын төв, хот суурин газруудад хөрсний чичирхийллийн хурдатгал бичигч станцын сүлжээг байгуулах” ажлын хүрээнд 2023 онд Дорнод аймгийн нутаг дэвсгэрт 2 ширхэг төхөөрөмжийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| Хууль сахиулах салбарын хөгжил | | | | | | | | | |
| 76 | Зорилт | 3.7 | Хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана. | тоо | Гэмт хэрэг, зөрчлийн тоо | Аймгийн хэмжээнд 602 гэмт хэрэг, 20002 зөрчил | Гэмт хэргийг 590 буюу 0,3 хувиар, зөрчлийг 18920 буюу 1.3 хувиар бууруулна. | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны орон нутгийн төсөвт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд зориулж Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааны зардал 50,400,000 төгрөгийг суулгаж аймаг, орон нутгийн зүгээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд бодиттой дэмжлэг үзүүлсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор УАЗ-220695 маркын 2759дор, Toyota Prius20 маркын 8969дор Toyota Harreri маркын 00-29дор улсын дугаартай 75.9 сая төгрөгийн автомашинуудыг балансаас баланст | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шилжүүлэн авсан. Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/ ашиглалтад орсноос хойш засвар хийгдээгүй байсныг шийдвэрлүүлэн 20,6 сая төгрөг 2022 оны төсөвт тусгуулан засварласан. | |
| 77 | Арга хэмжээ | 3.7.1 | Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ. | 0<br>1 | Чойбалсан хотод камержуулалтын нэгдсэн систем төв байгуулагдсан эсэх | 0 | 1 | Аймгийн Цагдаагийн газрын телекамер хяналтын төвд гудамж, зам талбайн хяналтын 128 камер ашиглагдаж байгаагаас одоогийн байдлаар 124 камер бүрэн ажиллагаатай байна. Хэрлэн сумын хэмжээнд гудамж талбайн камерын засвар, үйлчилгээ хийх график хуваарийг гаргаж, “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-тай хамтран хуваарийн дагуу засвар үйлчилгээ хийж ажиллаж байна. Аймгийн орох гарах 3 гүүр, аймгийн авто замын хяналтын 15 камер, байрнуудын гадна суурилуулсан 75 камер, мал махны цэгийн 20 камер, гудамж талбайн 14 камер, Цагдаагийн газрын 1, 2 дугаар байрны дотор, гадна орчны 27 нийт 151 камерыг жижүүрийн теле хяналтын камерын өрөөнд хянаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Дотоод аюулгүй байдлыг хангах” /код 113/, барилга байгууламжийн гадна, дотор орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор суурилуулсан 13 сум дундын цагдаагийн тасаг, хэсгийн байрны 14 теле хяналтын камер үйл ажиллагааг цагдаагийн газрын дэд, эрүүгийн цагдаагийн тасгийн дарга өдөр тутам гар утсаар хяналт тавьж ажиллаж байна. Тус аймгийн Хөлөнбуйр сумын замын цагдаагийн постод замын хяналтын 2 ширхэг камер ажиллаж байна. | 50 |
| 78 | | 3.7.2 | Төрийн байгууллагад хандан гаргаж буй иргэдийн өргөдөл, гомдлыг цахимаар хүлээж авах нэгдсэн системийг бий болгож, иргэдэд түргэн шуурхай | 0<br>1 | Цахим үйлчилгээ нэвтэрсэн эсэх | 0 | 1 | Төрийн байгууллагад болон төрийн албан хаагчдад хандаж буй өргөдөл, гомдлыг аймгийн цахим сайт dornod.gov.mn иргэдээс цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Мөн “Эйбл Софт” ХХК-тай төрийн байгууллагад хандан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээ үзүүлнэ. | | | | | гаргаж буй иргэдийн өргөдөл, гомдлыг цахимаар хүлээж авах нэгдсэн системийг бий болгохоор гэрээ байгуулан бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | |
| 79 | | 3.7.3 | Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, сайжруулна. | тоо | Дэмжлэг үзүүлсэн байгууллага, нэр төрөл, тоо | Байгууллага 2 Парк шинэчлэлт 10 тоног төхөөрөмж 5 | Байгууллага 4 Парк шинэчлэлт 20 тоног төхөөрөмж 15 | Аймгийн 2022 оны төсөвт “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” чиглэлээр 10 сая төгрөг тусгагдсан. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн алба хаагчдад 15 ширхэг мини камерт 8.8 сая төгрөг, X.Cover маркийн бэлэн бус торгуулийн багаж 1.7 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний албад BX-41 Olympus загварын микроскоп 14.9 сая төгрөгийг шийдвэрлэсэн. | 70 |
| Батлан хамгаалах салбар | | | | | | | | | |
| 80 | Зорилт | 3.8 | Батлан хамгаалах салбарын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, сургалт бэлтгэлийг хангах, томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ. | кофицент | Бэлэн байдлын дээшлэлт | 0.97 | 1 | Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүнээр, авто техникээр нөхөн хангах төлөвлөгөө шинэчлэгдэн батлагдсан бөгөөд төлөвлөсөн сургалт бэлтгэлийг Дорнод аймгийн дайчилгааны цугларах байрыг аймгийн Засаг даргын 2021 оны мн/.. захирамжаар Политехникийн коллеж ажилчдаар томилж, хичээлийн байрыг дайчилгааны бэлтгэл үүрэгтэн цугларах байраар бэлтгэж, томилгоот бие бүрэлдэхүүнд 4 өдрийн 12 цагийн сургалтын зохион байгуулсан. Техник шилжүүлэх байрны томилгоот бие бүрэлдэхүүнд 2 өдрийн 12 цагийн сургалтыг зохион байгуулж бие бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагааг хангаж, үүрэгт нь сургаж бэлтгэсэн. Орон нутгийн хамгаалалтын нэгжийн хамгаалалтын салааны 30 хүнд хээрийн аранзыг хүн нэг бүрийн тоогоор бэлтгэж, өвлийн улиралд үүрэг гүйцэтгэхэд дулаан хувцас, хүрэм, өмд, малгай, 3 хоногийн хүнс, хуурай хэрэглэл, аяны хөнжил, ариун | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэврийн хэрэгсэл, гар чийдэн, дулаацах хэрэгсэл болон бусад зүйлсийг бэлтгэсэн. Аймгийн Засаг даргын Захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын нэгжийн томилгоот бие бүрэлдэхүүнд сургалт, дадлага явуулах зарлан дуудах хуудсыг Хэрлэн сумын багийн ажлын албаар дамжуулан таараалган цуглуулж сургалт, дадлагыг зохион байгуулсан.<br>Орон нутгийн хамгаалалтын нэгжийн хамгаалалтын сумангийн 130 бэлтгэл үүрэгтэнг цуглуулж "Улсын онц чухал объектыг хууль хүчний байгууллагатай хамтран хамгаалалтад авах" гэсэн сэдвийн хүрээнд 3 өдрийн 12 цагийн сургалтын зохион байгуулсан. Сургалтыг үүссэн цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан, цаашид томилгоот бие бүрэлдэхүүний сургалт, дадлагад ашиглах зорилгоор телевизийн бичлэг хийж бэлтгэсэн. | |
| 81 | Арга хэмжээ | 3.8.1 | Хугацаат цэргийн алба хаах иргэдэд Цэрэг-Эх орончүзлийг төлөвшүүлэн, эрүүл мэндийг сайжруулж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | хувь | Эрүүл мэнд ээр тэнцэхгүй байгаа цэргийн насны залуучуудын нийт цэргийн насны иргэдэд эзлэх хувь | 70 | 50 | Цэргийн насны залуус нь 2022 онд мэс заслын шалтгаант эмгэг 142, дотрын шалтгаант эмгэг 133, чих хамар хоолойн шалтгаант эмгэг 76, нүдний шалтгаант эмгэг 43, арьс харшлын шалтгаант эмгэг 23 бүртгэгдсэн байна. Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгээр эрүүл мэндээр тэнцээгүй ч эмчлэгдэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх чиглэлээр ЭМГ, Цэргийн штаб хамтарсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн. Цэргийн алба хаах насны залууст эрүүл мэнд болон сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг цэрэг татлагын үед зохион байгуулсан. Цэргийн албаны ээлжит татлагаас чөлөөлөгдсөн иргэдийн мэдээллийн сан бүрдүүлсэн. Ээлжит татлагаас эрүүл мэндийн улмаас чөлөөлөгдсөн мэдээллээс цаашид эмчлэгдэх боломжтой цэргийн насны залуучуудыг төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээнд хамруулсан. Эмчилгээний хамрагдалт 2018 онд эмчлэгдэх боломжтой залуусын 15.3%, 2019 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | онд 50.5 хувь, 2020 онд 36.3 хувь, 2021 онд 20.3 хувь, 2022 оны байдлаар 22.2% нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд эрүүл мэндээр тэнцээгүй залуусын хувь багассан эерэг үр дүн гараад байна. | |
| 82 | | 3.8.2 | Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх, сургалт бэлтгэлийн төв байгуулна. | 0 1 | Тоног төхөөрөмж, тусгай багаж хэрэгсэл, байр бий болсон эсэх | 0 | 1 | Орон нутгийн хамгаалалтын нэгжийн хамгаалалтын салааны 30 хүнд хээрийн аранз-30ш, өвлийн улиралд үүрэг гүйцэтгэхэд дулаан хувцас, хүрэм-30ш, өмд-30ш, малгай-30ш, аяны хөнжил-30ш, гүц-30ш гар чийдэн-30ш, дулаацах хэрэгсэл-30ш, тус тус бэлтгэсэн. Орон нутгийн нэгжийн болон орон нутгийн цэргийн сургалт бэлтгэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг үе шаттай зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамран сургалтын төв байгуулах газрыг судлан, барилга байгууламж барих төсөв санхүүгийн тооцоо судалгаа гарган. бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70 |
| 83 | | 3.8.3 | Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, дайчилгаа удирдах бүлэгтэй сургалт явуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | 0 1 | Төлөвлөгөө батлагдсан эсэх | 0 | 1 | Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүнээр, авто техникээр нөхөн хангах төлөвлөгөө шинжлэгдэн батлагдсан бөгөөд төлөвлөсөн сургалт бэлтгэлийг Батлан хамгаалах товчооны бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, дайн бүхий байдлын үед томилгоот бүрэлдэхүүний үндсэн үүргийн талаар сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| | | | | тоо | Сургалтын тоо | 1 | 2 | | |
| Дархан хил | | | | | | | | | |
| 84 | Зорилт | 3.9 | Хилийн аюулгүй байдлыг хангах бүсчилсэн хил хамгаалалтыг сайжруулах зорилгоо дэд бүтцийг хөгжүүлнэ. | хувь | Арга хэмжээний хэрэгжилт | - | 100 | Хилийн 0198 дугаар Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөрийг хэрэгжүүлж, 0188 дугаар салбар /Задгайт/-ын албаны байр, 6 айлын орон сууцыг шинээр барих ажил 70 хувьтай явагдаж байна. Хилийн цэргийн 0104 дүгээр салбар /Баянхошуу/-т 6 айл, тавиулан, агуулах барих ажлын материалыг Улаанбаатар хотоос татах ажлыг зохион байгуулж байна. Хилийн 0275 дугаар ангийн Хилийн 0191, 0104 дүгээр | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | салбаруудад дулааны шугам, 2 гүний худаг гаргах ажлыг 6 дугаар сард хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хилийн 0275 дугаар ангийн 0266, 0307 дугаар салбаруудад (Гэрээт цэргийн байр, 16 айлын орон сууц)-ийг шинээр барихаар ХХЕГ-аас 2023 онд барилга байгууламжийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд багтсан. Хилийн 0306 дугаар анги Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангаж бүсчилсэн хил хамгаалалтыг сайжруулах зорилгоор 2 хилийн цэргийн салбарыг өндөр хүчдэлийн шугамд холбох техникийн нөхцөлийг Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-иар гаргуулсан. | |
| 85 | Арга хэмжээ | 3.9.1 | Улсын хилийн боомтын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, технологи, арга туршлагыг нэвтрүүлнэ. | тоо | Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн тоо | - | 8 | Хилийн 0198 дугаар ангид хилийн Баянхошуу, Сүмбэр боомтуудад 16 нэр төрлийн 62 ширхэг шалгалтын техник хэрэгслийг шинээр суурилуулан албанд ашиглаж байна Хилийн 0275 дугаар ангид ХХЕГ-аас 2022 онд Улсын хилийн боомтын шалган нэвтрүүлэх албанд 22 техник хэрэгслийг нэвтрүүлсэн. | 100 |
| 86 | | 3.9.2 | Улсын хил хамгаалалтын зориулалттай барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн төхөөрөмжийг шинэчилнэ. | тоо | Шинээр баригдсан барилга байгууламж, дэд бүтцийн тоо | - | 7 | Хилийн 0198 дугаар анги цэргийн салбаруудын хариуцсан хэсэгт 50 км торон саад барих ажлын бэлтгэлийг хангаж байна. Хилийн 0179 дүгээр салбарын хариуцсан хэсэгт шинээр телекамер суурилуулах зорилгоор хянах цамхаг шинээр барьсан. Хилийн 0275 дугаар ангийн 0102 дугаар салбарт Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж /Хянах цамхаг/ 2022 онд сэргээн засварлаж, 2022 онд Hikvision DS-2 маркийн өдөр шөнийн дурантай камер, MHL-19 маркийн прожектор 2 ширхэгийг шинээр суурилуулсан. Хилийн 0306 дугаар ангид Монгол Улсын ХЗДХ сайдаас Аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээний дагуу Хилийн цэргийн 0162 дугаар салбар /Бага хүрээ/-ын албаны байрны их засварын ажлын бэлтгэлийг бүрэн хангасан. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хариуцсан хэсэгт хийгдэх инженерийн байгууламж шинээр байгуулах төлөвлөгөөний дагуу 23 км газарт татах хилийн торон саадын байгууламжийн бэлтгэлийг бүрэн хангасан. Улсын хилийн тэмдгийн дагуу дуйралган дүрслэх хэрэгсэл 25 ширхгийг байрлуулсан. Бага хүрээ, Хавцал булагын хариуцсан хэсэгт 83 м гүнтэй 2 худаг шинээр гаргасан. | |
| 87 | | 3.9.3 | Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, хилийн зөрчлийг таслан зогсоох, иргэдэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | тоо | Хилийн зөрчлийн тоо | - | 0 | Хилийн 0132 дугаар анги тайлант хугацаанд хил орчмын дэглэмийн зөрчил гарсан 1 удаагийн 3 хүн, бэлчээрээр улсын хилд тулсан 10 удаагийн 563 толгой малыг илрүүлэн 12 хүнд 1.200,000 төгрөг /нэг сая хоёр зуун мянга/-ийн торгууль ногдуулж, ард иргэдэд учирч болзошгүй 703.7 сая төгрөг /долоон зуун гурван сая долоон зуун мянга/-ийн хохирлоос урьдчилан сэргийлсэн.Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хил орчмын дэглэмийн зөрчил 15.5 хувь, хариулгагүй мал бэлчээрээр улсын хилд тулсан зөрчил 72.4 хувиар тус тус буурсан. Хил орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт 100 хувьтай байна. Хилийн 0198 дугаар ангийн 0190, 0150 дугаар салбаруудын Улсын хилд тулсан 3 удаагийн 266 тооны адуу цаг тухайд нь илрүүлж, ард иргэдэд учирч болох 133,000,000/Нэг зуун гучин гурван сая/ төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлсэн. Хилийн 0275 дугаар ангийн 0207 дугаар салбар 2022 онд 31 км спирал торон саадыг шинээр байгуулж 2021 онд 25 удаагийн 1331 тооны мал, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 10 удаагийн 240 тооны мал улсын хилд тулсан зөрчлийг илрүүлж, иргэдэд учирч болзошгүй 1 тэрбум 200,000,000 төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Хилийн 0306 дугаар анги тайлант хугацаанд Хил орчмын дэглэмийн зөрчил 2 удаа гарсныг илрүүлэн шийдвэрлэж, ард иргэдэд учирч болох 39,5 сая төгрөгийн | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хохирлоос урьдчилан сэргийлж, 2022 оны 03 дугаар сард Матад сумын нутаг Цувраа цагаан толгой, Халх гол сумын нутаг Хонхорын товог, Хар өндөр зэрэг газруудад гарсан тал хээрийн түймрийг тухай бүр нь унтраах арга хэмжээ авч ард иргэдийн өвөлжөө, хаваржааны нутаг дэвсгэрийг хамгаалсан. Газрын тосны XIX талбайн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдэд Цагдаа, Гадаадын иргэдийн харьяатын газар, Тагнуулын тасагтай хамтарсан төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулж, Монгол Улсын хилийн тухай хуулиар яриа таниулга хийж, иргэн аж ахуйн нэгжүүдээс баталгаа авсан. | |
| | ДӨРӨВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА | | | | | | | | |
| 88 | Зорилго | 4 | Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах *__нөхцөлийг__* сайжруулан инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдрах хүн амын эзлэх хувийг 5 хувиар нэмэгдүүлнэ. | тоо | Шинээр орон сууцаар хангагдсан өрхийн тоо | 84 | 1000 | Аймгийн хэмжээнд 2021 онд нийт 358 айлын 8 орон сууц тус тус ашиглалтад орсон бол 2022 онд Хэрлэн сумын 4 дүгээр багт иргэн А.Амартүвшингийн захиалгаар баригдсан 45 айлын үйлчилгээтэй, орон сууцны барилгын 2 блок, 6 дугаар багт “Сүхжин” ХХК-ийн барьсан 60 айлын, 7 дугаар багт “Тод сүндэрэл” ХХК-ийн барьсан 24 айлын, 11 дүгээр багт “Их базар констракшн” ХХК-ийн барьсан 54 айлын, “Стандард резидэнс констракшн” ХХК-ийн барьсан 40 айлын үйлчилгээтэй орон сууцны, нийт 268 айлын 6 блок орон сууцны барилга ашиглалтад ороод байна.<br>Одоогийн байдлаар Хэрлэн сумын 1 дүгээр багт иргэн П.Гэрэлбаатарын захиалгаар “Гранд Лакс Констракшн” ХХК-ийн гүйцэтгэж буй “LUX TOWN” хотхоны 1 дүгээр ээлжийн тус бүр 60 айлын тоосгон өрөгт бүтэц бүхий 5 давхар орон сууцны 2 барилга, “Сувд шилтгээн” ХХК-ийн захиалгаар Хэрлэн сумын 2 дугаар баг, Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжинд тус бүр 30 айлын 2 орон сууцны барилга, “Монмарс” ХХК-ийн Марс | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хотхоны 72 айлын 1 орон сууцны, нийт 252 айлын 5 орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна. | |
| | Хөдөлмөрийн зах зээл | | | | | | | | |
| 89 | Зорилт | 4.1 | Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 2019 онд 44 хувь байсныг 2025 онд 63 хувьд хүргэнэ. | хувь | Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | 44 | 63 | Хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлогын хүрээнд ажил идэвхтэй хайгч иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 1061 иргэнд, бүлгийн зөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон мэргэжлийн боловсролын байгууллагын 1364 суралцагчдад өгсөн. Мөн 1568 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 121 төсөл сонгон шалгаруулж, 770,0 сая төгрөгийг зарцуулан байнгын ажлын байраар хангаснаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53,5 хувьд хүрсэн. | 100 |
| 90 | Арга хэмжээ | 4.1.1 | Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шинэчилсэн хууль тогтоомжийн дагуу үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | тоо | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй цалин авдаг байгууллага | 150 | 450 | Хөдөлмөрийн тухайн хуулиар (шинэчлэгдэн баталсан) төрийн болон хувийн хэвшлийн 180 байгууллагын 670 гаруй ажилтнуудад хуулийн хэрэгжилтээр сургалт, зөвлөгөө мэдээллийг хүргэж, сурталчилсан. | 100 |
| 91 | | 4.1.2 | Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, бүс, орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах зорилтот ажлуудыг зохион байгуулна. | хувь | Ажилгүйдлийн түвшин | 20,9 | 7 | Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 21 хоногийн хугацаатай мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд зарласан. Төслийн хугацаанд аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 65 төсөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 29 төсөл, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 25 төсөл, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1 төсөл, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Стар ап арга хэмжээнд 1 иргэний нийт 121 төсөл сонгон шалгаруулж, 770,0 сая төгрөгийг олгож, байнгын ажлын байраар хангасан. Нийт 1568 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилснаар аймгийн ажилгүйдлийн түвшин 8,4 хувьтай байна. | |
| 92 | | 4.1.3 | Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | хувь | Ажлын байр | 60 | 90 | Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч иргэд болон ажил олгогч иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг тухай бүр цахим хуудсанд нээлттэй байршуулж, 1000 иргэдэд хүргээд байна. Мөн тухайн мэдээллийг цахим хуудсанд байршуулан цахим болон зайнаас ажиллах боломжийг иргэдэд хүргэж, ажилласны үр дүнд цахим орчныг ашиглан 106 иргэн түр болон байнгын ажлын байртай болсон байна. | 100 |
| 93 | | 4.1.4 | Төр, хувийн хэвшлийн “Хөдөлмөрийн бирж”-үүдийг байгуулах ажлыг дэмжиж, ажлын үр дүн, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | тоо | Хөдөлмөрийн бирж | 4 | 5 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/75 дугаар тушаалаар Хөдөлмөрийн хувийн биржийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 6 байгууллага бүртгэгдсэн. Хөдөлмөрийн хувийн биржүүдэд ажил хайгч иргэнийг бүртгэх, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан ашиглалтын талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөөг 6 удаа танхимаар, 2 удаа цахимаар өгсөн. | 100 |
| 94 | | 4.1.5 | Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх “Старт апп төв”, “Жижиг дунд | тоо | “Жижиг дунд үйлдвэрлэлийн төв” | 0 | 1 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Start-up арга хэмжээнд аймгийн хэмжээнд 8 баг өрсөлдөж, 3 баг нь хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж, олон нийтэд нээлттэй төслөө танилцуулан “Мойлхон” оёмол хүүхдийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 95 | | 4.1.6 | үйлдвэрлэлийн төв" байгуулна. | | | | | тоглоомын үйлдвэрлэх баг шалгарч, 10,0 сая төгрөгийг дэмжлэгт хамрагдан байнгын ажлын байраар хангагдсан. "Start up" төвд нийт 18 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, залуучуудын хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ, шинэлэг санааг хөгжүүлэх, залуу бизнес эрхлэгчдийг холбох, хамтарч хөгжих боломжийг бий болгож байна. | |
| | | | Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн зорилтот бүлэг /Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэн/-ийн иргэдийг сургалт мэдээллээр хангаж, ажлын байранд зуучлах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | тоо | Ажилд зуучилсан иргэдийн тоо | 157 | 180 | Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй өрхийн иргэн болон ажил идэвхтэй хайж байгаа 258 иргэнд "Эм Эс Девелопменг ХХК-тай хамтран хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн хөдөлмөрийн болон харилцааны сэтгэл зүй, соёл төлөвшүүлэн зөв хандлагатай мэргэжилтэн бэлтгэх талаарх шаардлагатай ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж байнгын ажлын байранд 51 иргэн, түр ажлын байранд 180 иргэнийг хамруулж, 90 хувь нь түр болон байнгын ажлын байраар хангасан. | 90 |
| | | | | тоо | Ажиллуулах байгууллагын тоо | 98 | 115 | | |
| Хот төлөвлөлт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө | | | | | | | | | |
| 96 | Зорилт | 4.2 | Төр, иргэн хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалт менежментийг хариуцсан нэгжийг байгуулж, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрыг дахин төлөвлөх ажлыг хэрэгжүүлнэ. | тоо | Дахин төлөвлөлт хийсэн байршлын тоо | 0 | 3 | 1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах", "Чойбалсан хотын /хуучин төв/ 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах" ажлын даалгаврын дагуу зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр "Нарт дизайн" ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.<br>2.Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд "Тод сүндэрэл" ХХК-ийн Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт гэр хорооллын 0,8 га газарт дахин төлөвлөлт хийж, 135 айлын орон сууцны хотхоны барилга угсралтын ажил дууссан.<br>3.Хэрлэн сумын 2 дугаар багт 1,85 га гэр хорооллын газарт 400 айлын орон сууцны | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хороолол барих ажлыг эхлүүлээд байгаа ба 2,1 га газарт дахин төлөвлөлт хийж, 30 айлын 2 орон сууцны барилгын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 90 хувьтай. | |
| 97 | Арга хэмжээ | 4.2.1 | Гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй болгох ажлыг хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар солих замаар дараагийн орон сууц баригдах газрыг бий болгоно. | тоо | Орон сууц барих зориулалтаар чөлөөлсөн газрын тоо | 0 | 2 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд “Тод сүндэрэл” ХХК Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэний өмчлөлийн 0,8 га газарт дахин төлөвлөлт хийж 135 айлын орон сууцны хотхоны барилга угсралтын ажлыг хэрэгжүүлж дуусан. мөн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэний өмчлөлийн 1,85 га газарт 400 айлын орон сууцны хороолол барихаар төлөвлөн энэ онд 2,1 га газарт дахин төлөвлөлт хийж 30 айлын 2 орон сууцны барилгын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 |
| 98 | | 4.2.2 | Хэрлэн сумын “Ивээл”, “Буйр” хороолол, Хан-Уул гудамжны эхний эгнээг дахин төлөвлөж барилгажуулах ажлыг эхлүүлнэ. | 0<br>1 | Дахин төлөвлөлт хийсэн эсэх | 0 | 1 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгөөр Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулахаар батлсны дагуу ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж дуусан магадлалаар хянуулах шатанд байна. Зураг төсвийг хүлээн авсны дараа дахин төлөвлөж барилгажуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | 50 |
| 99 | Зорилт | 4.3 | Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн орон байраар хангана. | тоо | Инженерийн хангамж бүхий орон сууцанд амьдарч байгаа өрхийн тоо | 6846 | 7500 | 2022 онд нийт 268 айлын 6 блок орон сууцны барилга ашиглалтад ороод байна.<br>Одоогийн байдлаар Хэрлэн сумын 1 дүгээр багт иргэн П.Гэрэлбаатарын захиалгаар “Гранд Лакс Констракшн” ХХК-ийн гүйцэтгэж буй “LUX TOWN” хотхоны 1 дүгээр ээлжийн тус бүр 60 айлын тоосгон өрөгт бүтэц бүхий 5 давхар орон сууцны 2 барилга, “Сувд шилтгээн” ХХК-ийн захиалгаар Хэрлэн сумын 2 дугаар баг, Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжинд тус бүр 30 айлын 2 орон сууцны барилга, “Монмарс” ХХК-ийн Марс | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хотхоны 72 айлын 1 орон сууцны, нийт 252 айлын 5 орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна. | |
| 100 | Арга хэмжээ | 4.3.1 | Хот суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, хүн амын орлогод нийцсэн, аюулгүй, ая тухтай, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц барих ажлыг зохион байгуулна. | тоо | Ашиглалтад орсон нийтийн орон сууцны тоо | 229 | 240 | Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 48 га газарт 1000 айлын хороолол барихаар төлөвлөн гадна инженерийн шугам сүлжээ барих ажлыг хэрэгжүүлсэн. Одоогийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Гидродизайн инноваци” ХХК, “Их мянган инженерчлэл” ХХК-иуд хорооллын дотор инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу боловсруулж байна. Энэ онд хувийн хөрөнгө оруулалтаар 268 айлын 6 блок орон сууцны барилга ашиглалтад орсон. | 100 |
| 101 | | 4.3.2 | Гэр хорооллын өрхийн газрыг иргэдийн өөрсдийнх нь идэвх санаачилга, оролцоонд тулгуурлан дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлнэ. | тоо | Дахин төлөвлөлт хийгдсэн байршлын тоо | 0 | 2 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар иргэний гэр бүлийн хэрэгцээнд өмчилсөн байршил болох Хэрлэн сумын 1, 2, 4, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 237 айлын орон сууцны ногоон байгууламж, тоглоомын талбай бүхий орон сууцны хотхон хороолол барих ажлыг аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлж байна.<br>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгөөр Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулахаар батлсны дагуу ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж дуусан магадлалаар хянуулах шатанд байна. Зураг төсвийг хүлээн авсны дараа дахин төлөвлөж барилгажуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | 100 |
| 102 | | 4.3.3 | Барилгын материал, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг дотооддоо үйлдвэрлэх санал | тоо | Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн | 0 | 5-аас доошгүй | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан болон хоршоог хөгжүүлэх сангаас барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр зээл олголт хийгдээгүй байна. | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санаачлагыг дэмжиж, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлд хамруулах замаар хэрэгжүүлнэ. | | тоо | | | | |
| Газрын харилцаа | | | | | | | | | |
| 103 | Зорилт | 4.4 | Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлнэ. | хувь | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 70 | 70-аас доошгүй | Салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Тайлант хугацаанд гарсан зөрчил байхгүй. | 100 |
| 104 | Арга хэмжээ | 4.4.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгоно. | тоо | Тодотгосон ерөнхий төлөвлөгөөний тоо | 0 | 1 | Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран хэрэгжүүлж буй “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төслийн хүрээнд Дорнод аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, Булган, Матад, Хөлөнбуйр сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг орон нутгийн төсвийн 457.0 сая төгрөгөөр боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Гео ботаник” ХХК /”АТТП” ХХК-тай түншлэлтэй/ шалгарч, ажлын даалгаврын дагуу бэлтгэл ажлын тайланг 2022 оны 04 дүгээр сард иргүүлж, аймаг, сумдын удирдлага, төслийн багийн уулзалтаар тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан. Ажлыг 2022 оны 12 дугаар сард хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Мөн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд Баяндун, Баян-уул, Баянтүмэн, Гурванзагал, Чулуунхороот, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Чойбалсан сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэл 96 хувьтай байна. | |
| 105 | | 4.4.2 | Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурин тодорхойлж, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | тоо | Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан сумын тоо | 4 | 14 | Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран хэрэгжүүлж буй “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төслөөс Булган, Матад, Хөлөнбуйр сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслөөс Баяндун, Баян-уул, Баянтүмэн, Гурванзагал, Чулуунхороот, Чойбалсан сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг хэрэгжүүлж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай, тайлант онд хийгдэх ажил бүрэн хэрэгжсэн. | 70 |
| 106 | | 4.4.3 | Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зүй зохистой ашиглана. | хувь | Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 80-аас доошгүй | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад хяналт тавин ажиллаж байна.<br>Сумдын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 70-80 хувьтай байна. | 90 |
| ТАВ.ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | | | |
| | Зорилго | 5 | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн салбарыг дэмжин хөгжүүлж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг жилд 10- | Сая.төг | Дотоодын нийт бүтээгдэхүүн | 940428.78 | 1,278159.5 | Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооллыг Үндэсний статистикийн хорооноос жилийн эцсээр дүгнэж тооцон танилцуулдаг бөгөөд ДНБ тооцоолол 2021 оны байдлаар гараагүй | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | | | аас доошгүй хувиар өсгөнө. | Мян.төг | Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ | 11446.73 | 14835.24 | байна. | 0 |
| Эдийн засаг, санхүү | | | | | | | | | |
| | | | зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, багийн үйл ажиллагааг сайжруулна. | | хэрэгжилт | | | үзүүлэлтийг хангасан Дашбалбар сумын “Чух” баг, Цагаан-Овоо сумын “Хүрээт” баг, аймгийн төвийн Тэргүүний багаар Хэрлэн сумын “4 дүгээр” багууд тус тус шалгарч тус бүрд 1.000.000 төгрөгийн урамшуулсан олгосон. Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч нартай аймгийн Засаг дарга, сум, багийн Засаг дарга, хэсгийн ахлагч нар дөрвөлсөн гэрээ байгуулж, багийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагад Монгол Улсын хууль тогтоомж, орон нутгийн бодлого шийдвэрийг шуурхай хүргэх, мэдээлэх, багийн үйл ажиллагааны дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулан хамтран ажиллаж, мэдээлэл холбоо, унааны зэрэг шаардагдах 50.000 төгрөгийн урамшууллыг сар бүр хэсгийн ахлагч нарт олгосон. Мөн “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-2”-ийн хүрээнд Дорнод аймгийн 14 сумын 67 багийн Засаг дарга нарыг чадавхжуулах, арга зүйгээр хангах, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Цэргийн штаб, Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газраас багийн Засаг дарга нарыг чадавхжуулах, сургалтыг багийн Засаг дарга нарын зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. | 100 |
| 160 | | 6.1.5 | Төрийн байгууллагуудын зарим үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангана. | тоо | Төрийн бус байгууллагаар гүйцэтгэсэн төрийн үйлчилгээ | 7 | 15 | Төрийн зарим чиг үүргийн төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоотой Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр байгуулж, ард иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангуулан ажилладаг. Мөн хүмүүнлэгийн чиглэлээрх зарим чиг үүргийг Монголын Улаан загалмайн нийгэмлэг үндэсний хүмүүнлэгийн байгууллагын Дорнод аймаг дахь салбараар гэрээний дагуу гүйцэтгүүлдэг. Эмэгтэйчүүдийн | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжил хөтөлбөр, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрүүдийг иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж, Ахмадын ачлал хөтөлбөрийг Ахмадын зөвлөх баг, Ахмадын хороо зэрэг байгууллагуудын оролцоотойгоор зарим чиг, үүргийг хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан жил бүр гүйцэтгүүлж, үнэлэлт, дүгнэлт өгч, хэрэгжүүлэх хугацааг нь сунгаж, хамтран ажилладаг. Мөн Чойбалсан хотын нийтийн тээврийн 7 чиглэлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэ төлбөргүй зорчуулах үйлчилгээг Авто тээврийн үндэсний төвийн Дорнод салбараас зорчигч тээврийн үйлчилгээний “АйсВН” ХХК, тээвэр гүйцэтгэгч жолооч нартай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. | |
| 161 | | 6.1.6 | Төрийн албан хаагчдын цахим сургалт, шалгалт, мэдээллийн нэгдсэн төв байгуулна. | 0<br>1 | Төв байгуулагдсан эсэх | 0 | 100 | 2022 онд төсөв батлагдаагүй | 0 |
| 162 | | 6.1.7. | Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын барилгын засвар, автомашины парк шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. | тоо | Засвар хийсэн барилга<br><br>Парк шинэчлэл хийсэн автомашин | -<br><br>- | 13<br><br>10 | 2022 оны жилийн байдлаар төр, нутгийн захиргааны байгууллагын автомашины парк шинэчлэлт, засварыг 1 агентлаг авто машины парк шинэчлэлт хийсэн. | 30 |
| | Ухаалаг бүтэц | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 163 | Зорилт | 6.2 | Мэргэшсэн төрийн албан хаагчийг 20 хувиар нэмэгдүүлж, мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ. | хувь | Ур чадвар нэмэгдсэн албан хаагч нийт төрийн албан хаагчид эзлэх хувь | 6 | 20 | Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг мэргэшүүлэхэд анхаарч сум, агентлагаас мэргэшсэн байдлын судалгаа авч хамруулж байна. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад аймгийн Засаг даргын тамгын газрын болон сум, агентлагийн нийт 44, богино хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 49 албан хаагч тус тус хамрагдсан байна. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох нөхцөл, болзлыг хангасан ахлах түшмэл 17, дэс түшмэл 86, туслах түшмэлийн 44 нийт 147 нэр бүхий төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо 2021 оны мөн үетэй харьцуулбал 50 хувиар өссөн үр дүнтэй байна. | 100 |
| 164 | Арга хэмжээ | 6.2.1 | Сумдад орон нутгийн өмчийн орон сууцыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана. | Тоо | Орон сууцны дэмжлэг авсан төрийн албан хаагч | 19 | 44 | Албан хаагчдын орон сууцны судалгаар нийт 14 сумын Засаг даргын тамгын газар гаргаж, дэмжлэг тусламж шаардлагатай албан хаагчдын мэдээлэлтэй болж амьдрах орчин нөхцөлөө сайжруулсан, шинээр гэр, орон сууц худалдан авсан, засвар хийсэн, хашаа хороогоо сайжруулсан зэрэг 26 албан хаагчдад хамт олон, байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>Мөн 2019 оноос эхлэн “Нутгийн ирээдүй” орон сууцны төсөл хэрэгжиж Булган, Чойбалсан, Матад сумдууд нийт 18 айлын орон сууц баригдсан ба 2022 онд Гурванзагал, Чулуунхороот сумдууд нийт 16 айлын орон сууцыг барьж эхлүүлээд байна. | 100 |
| 165 | | 6.2.2 | Орон нутгийн мэргэжил олгох сургуулиудыг түшиглэн төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтуудыг зохион | Тоо | Сургалтын тоо | 4 | 24 | Төрийн албан хаагчдыг ажлын байранд нь сургах, чадавхжуулах, орон нутагт нь мэргэшил дээшлүүлэх, боловсрол эзэмшихэд ажлын цагийн хөнгөлөлт үзүүлэх, цалинтай чөлөө олгох, төлбөрийн уян хатан нөхцөл үзүүлэх, сум | 50 |
| | | | | Тоо | Хамрагдсан албан | 240 | 1200 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулна. | | хаагч | | | орон нутагт нь багш нар очиж хичээл заах зэргээр хамтран ажиллаж дэмжлэг үзүүлснээр Дорнод их сургуульд 106 магистр, докторантад 24 албан хаагч суралцаж байна. | |
| 16 6 | | 6.2.3 | Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулж, ажлын байранд сурган, мэргэшүүлэх, төрийн байгууллага хооронд туршлага солилцох, сэлгэн ажиллуулах ажлыг хэрэгжүүлнэ. | Тоо | Сэлгэн ажиллаcан албан хаагч | 11 | 100 | Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын ХЭГ-ийн дарга, ТАЗ-ын даргын хамтарсан тушаалын дагуу аймгийн Засаг даргын тамгын газар болон сум, агентлагийн хэмжээнд нийт 26 албан хаагч сэлгэн ажиллаж, 73 албан хаагч шилжин ажилласан байна. | 100 |
| 16 7 | | 6.2.4 | Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэн бүрдүүлэх, шинээр төрийн албанд томилогдсон албан хаагчдыг сурган, чадавхжуулна. | Тоо | Төрийн албаны ерөнхий шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдсан иргэд | 174 | 800 | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн баталсан "Шинээр томилогдсон албан хаагчийг дадлагажуулах хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд байгууллагын онцлогт тохируулан чиглүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.Аймгийн Засаг даргын тамгын газар болон сум, агентлагт шинээр томилогдсон нийт 185 албан хаагч хамрагдсан байна.Мөн тус хөтөлбөрийн хэрэгжилт давуу болон сул талыг тодорхойлох туршлага солилцох танилцуулгыг Мерит төсөл хэрэгжиж байгаа Сүхбаатар, Төв, Дундговь аймгийн уулзалтад танилцуулсан, мөн аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 25 агентлагийн хүний нөөцийн сургалтад танилцуулж хэлэлцүүлсэн. | 100 |
| | | | | too | Шинээр томилогдсон албан хаагчдыг дадлагажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллага | 1 | 36 | | |
| 16 8 | | 6.2.5 | Нийт сумдад нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад | Тоо | Сургалтын төлбөри | 33 | 90 | 2019 оноос эхлэн орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудыг сургалтын төлбөрийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Нутгийн ирээдүй” төслийн хүрээнд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, сумдад дутагдалтай байгаа төрийн албан хаагчдыг бэлтгэнэ. | | йн тэтгэлэгт хамрагдсан оюутан | | | дэмжлэг үзүүлж, гэрээ байгуулах замаар сумын боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Нутгийн ирээдүй” төслийг хэрэгжүүлсэн. Жил бүр сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд нээлттэй, ил тод зарлаж ажилладаг ба 2022 онд 14 сумаас шалгарсан 30 оюутнуудтай гэрээ байгуулсан. 2019 оноос эхлэн нийт 109 оюутан тус тэтгэлэгт хамрагдсанаас 26 оюутан төгсөж сумдад нэн шаардлагатай мэргэжлийн орон тоог нөхөн, гэрээний дагуу ажиллаж байна. | |
| 169 | | 6.2.6 | Төрийн албан хаагчийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | хувь | Хөтөлбөрийн хэрэгжилт | 40 | 100 | Аймгийн Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийн зардалд 35,0 сая төгрөг батлуулан ажилласан.Хөтөлбөрийн хүрээнд аймгийн сум, агентлагийн албан хаагчдын дунд албан тушаалын тодорхойлолтын “Ур чадварын уралдаан”-ыг 2 дахь жилдээ, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад бэлтгэгчдийг дэмжих сургалтыг 2 удаа, төрийн албан хаагчдын дунд үндэсний хэв шинжийг сурталчлан таниулах олон төрөлт тэмцээн, санхүүгийн салбарын албан хаагчдын дунд шинэ санал санаачилгын уралдаан, төрийн албан хаагчдын сургалт хөгжил, нийгмийн баталгааг хариуцлагатай дэмжигч төрийн байгууллага шалгаруулах, ЗГХЭГ, ТАЗ, Удирдлагын академи, Канадын Мерит төсөл, бусад мэргэжлийн байгууллагатай хамтарсан сургалт, үйл ажиллагаа зэргийг зохион байгуулан ажилласан.Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чиглүүлэх, чадавхжуулах сургалтад нийт 109 албан хаагчдыг хамруулж ажилласан байна. Төрийн байгууллагын хүний нөөцийн ажилтан, албан хаагчдын 27 хүний бүрэлдэхүүнтэй “Хүний нөөцийг клуб”-ыг байгуулан 2 дахь жилдээ хамтран ажиллаж улирал бүр буюу 4 удаагийн уулзалт, сургалтыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зохион байгуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд сургалт, уралдаан, тэмцээний үнэлгээний ажилд хамтран ажиллаж, санал дүгнэлт солилцон ажиллаж байна. | |
| Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба | | | | | | | | | |
| 170 | Зорилт | 6.3 | Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын бүртгэл мэдээлэл сайжирч, ёс зүй, сахилга хариуцлагын зөрчил гаргасан албан хаагчдын тоог 5 хувиар бууруулна. | Тоо | Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч | 21 | 10 | Дорнод аймаг нь 2022 оны Ёс зүйг дээдлэх зорилтот жил болгон зарлаж, сум, агентлаг нийт 36 байгууллагын ёс зүйн зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх үүрэг бүхий “Ёс зүйн хяналтын зөвлөл”-ийг байгуулж, ёс зүйн жилийн төлөвлөгөө батлан ажиллалаа. Ёс зүйн жилийн төлөвлөгөөний дагуу 36 байгууллагын ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт ёс зүйн зөрчлийн бүртгэл, тайлан, төлөвлөлтийг сайжруулах нэгдсэн арга зүйн цахим сургалтыг төрийн захиргааны болон төрийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, хилийн цэрэг зэрэг салбарын 170 гаруй албан хаагчдад, ЗГХЭГ болон мэргэжлийн байгууллагатай хамтран “Аймгийн төрийн албан хаагчдын ёс зүйн зөвлөгөөн”-ийг 36 байгууллагын ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нийт 80 гаруй албан хаагчдад, суурь онд бүртгэгдсэн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийснээр урьдчилан сэргийлэх сургалтыг сум, агентлаг, соёлын салбарын нийт 8 байгууллагын 500 гаруй албан хаагчдад нийт 800 гаруй албан хаагчдад ёс зүйн дүрэм, журам, түүнээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүний үр дүнд ёс зүйн зөрчил гаргасан, хариуцлага хүлээсэн албан хаагчдын тоо 66 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| 171 | Арга хэмжээ | 6.3.1 | Ёс зүй, сахилга хариуцлагад хяналт тавих ажилд технологийн дэвшил, шинэ менежментийг нэвтрүүлж, | Тоо | Ёс зүй, харилцаа хандлаг | - | 20 | Төрийн байгууллагуудын албан хаагчдын ажлын үр чадвар, ёс зүй, харилцаа хандлагад иргэд шууд үнэлгээ өгөх нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардагдах 50 сая төгрөгийн | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түүнд үндэслэн төрийн албан хаагчдын сахилга, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэн, энэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | | ад иргэд шууд үнэлгээ өгөх нэгдсэн системийг нэвтрүүлсэн байгууллага | | | төслийг боловсруулан танилцуулсан. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг 4 албан хаагч гаргасан. Аймгийн 14 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар, 25 агентлагийн эрх бүхий албан тушаалтанд 01 дүгээр сарын 07-ны өдөр ХАСХОМ бүрдүүлэлттэй холбогдуулан 39 албан хаагчдад цахим сургалт зохион байгуулсан. Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвээр 02 дугаар сарын 21-ны өдөр 75 албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймаг, сумын албан тушаалтнуудад зориулан давтан сургалтад 02 дугаар сарын 22-ны өдөр 14 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлагийн нийт 18 албан хаагчдын сургалтад хамруулсан. Мөн тус газраас зохион байгуулсан 02 дугаар сарын 23-ны өдөр 21 аймгийн удирдах болон ахлах ажилтны давтан сургалт, 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг анхан шатны сургалтад 14 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлагийн 120 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Гадаадын иргэн харьяатын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэс, 14 сумын Засаг дарга, 67 багийн Засаг дарга, 25 агентлагийн дарга эрх бүхий албан тушаалтан нарт аймгийн авлигын эсрэг нөхцөл байдал, ашиг сонирхлын зөрчлийн тухай сэдвээр Нийт 326 алба хаагч сургалтад хамрагдсан. | |
| | | | | тоо | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөр шалгагдсан албан хаагч | 24 | 0 | | |
| | | | | тоо | Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч | 3 | 0 | | |
| | | | | тоо | Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээн | 2750 | 4774 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | д хамрагдсан албан хаагч | | | | |
| 172 | | 6.3.2 | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд сулагаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | тоо | Ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалт | 127 | 550 | Төрийн албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд 2 албан хаагч холбогдож хариуцлага хүлээлгэн шийдвэрлэгдсэн байна.<br>Аймгийн Засаг даргаас 2022 оны Ёс зүйг дээдлэх жил болгон зарласантай холбогдуулан 2021 оны жилийн эцсийн ёс зүйн бүртгэл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласнаар аймгийн нийт сум, агентлагийн 33 ёс зүйн зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх үүрэг бүхий аймгийн “Ёс зүйн хяналтын зөвлөл”-ийг байгуулсан.<br>Ёс зүйн жилийн төлөвлөгөөний дагуу ёс зүйн нарийн бичгийн дарга нарт арга зүйн цахим сургалтыг зохион байгуулж ажилласан бөгөөд сум, агентлаг, боловсрол, эрүүл мэнд, хилийн цэрэг, зэвсэгт хүчин зэрэг байгууллагын 170 гаруй албан хаагчид хамрагдсан. Мөн аймгийн Засаг даргын тамгын газраас ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 агентлагийн 40 гаруй албан хаагчдад зохион байгуулсан.Мөн сум, агентлагууд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 16 удаагийн сургалтад 340 гаруй албан хаагчдыг хамруулсан байна. | 70 |
| | | | | тоо | Хамрагдсан албан хаагч | 1670 | 4774 | | |
| Хяналт-шинжилгээ, үнэлгээ | | | | | | | | | |
| 173 | Зорилт | 6.4 | Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ. | хувь | Хэрэгжилтийн гүйцэтгэлээр | 0 | 100 | Аймгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан нь 11 үзүүлэлтийн дундаж үнэлгээгээр 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор дүгнэгддэг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 83.1 хувийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оноос 2.1 хувар өссөн үзүүлэлттэй | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байна. Мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.6 хувийн гүйцэтгэлтэй дүнэгдсэн байна. | |
| 174 | Арга хэмжээ | 6.4.1 | Орон нутгийн түвшинд захиргааны байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн тайлагналтын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, иргэдэд нээлттэй хүргэх, хадгалах үйл явц бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний “Цахим сан” нэвтрүүлнэ. | 0 1 | Цахим сан Нэвтрүүлсэн эсэх | 0 | 1 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн тайлагналтын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, иргэдэд нээлттэй хүргэх, хадгалах үйл явц бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санг нэвтрүүлэх ажлын төсөв энэ онд батлагдаагүй, 2023 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлээд байна. | 0 |
| 175 | | 6.4.2 | Аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад Хөндлөнгийн үнэлгээг мэргэжлийн судалгааны баг, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлнэ. | хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт | 0 | 100 | Монгол Улсын 2015 оны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 14.6-д “Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу 2024 онд хийхээр төлөвлөсөн боловч, 2020 оны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх заалт өөрчлөгдсөн тул хасах саналтай. | 0 |
| 176 | | 6.4.3 | Захиргааны байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг судлах Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн багаар гүйцэтгүүлнэ. | Оноо /1-5/ | | 3.16 | 3.30 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын журмын 9.6-д Захиргааны байгууллага нь хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийн дагуу хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр заасан боловч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор тус журам нь шинэчлэгдэн | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | батлагдаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна. Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно гэж өөрчлөлт орсны дагуу 2022 оны аймаг орон нутгийн төсөвт тусгагдаагүй тул түр хойшлогдоод байна. | |
| ДОЛОО. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | | |
| Байгалийн баялгийн үр өгөөж | | | | | | | | | |
| 177 | Зорилго | 7 | Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, уур амтсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохиоцох үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл аюулгүй орчинд амьдрах орчныг бүрдүүлнэ. | га | Ногоон байгуулалмжийн хэмжээ | 61.2 | 80.0 | Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтээр мод тарих” өдрөөр Чойбалсан хотын Найрамдал парк, Өүлэн эхийн хөшөөний цэцэрлэгт хүрээлэн, Нисэхийн зам дагуу байгуулсан ойн зурвас бусад нийтийн эзэмшлийн гудамж талбайд хавар, намрын өдрүүдэд давхардсан тоогоор 92 байгууллагын 1800 ажилтан, албан хаагч, 34 аж ахуйн нэгжийн 1233 ажилтан, 98 өрхийн 384 иргэн, 18 сургууль, цэцэрлэгүүд нийт 9317 иргэн хамрагдаж 15 гаруй нэр төрлийн 548.556 ширхэг мод тариад байна. | 100 |
| 178 | Зорилт | 7.1 | Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж ойжуулалтын хэмжээг өсгөн нэмэгдүүлж, хот, суурин, автозам, уул уурхайн хөрсний элэгдэл, эвдрэл, газрын доройтлыг бууруулна | хувь | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд доройтолд орсон газрын эзлэх | 40.0 | 35.0 | Түймэрт шатсан, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мод бэлтгэсэн 50 га талбайд ойжуулалт хийх ажлын тендер Баявж-барас ххк шалгарч Баян-Уул сумын “Ар битүүгийн баруун бие” гэх газарт 50 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэн аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг газар дээр нь очиж тооллого зохион байгуулж ойжуулалтын амьдралт хувийг 78%-тай гэж үзэн хүлээн авсан. Тус аж ахуйн нэгж нь ойжуулалтын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувь. | | | ажлаа 3 жил хариуцан өөрийн хөрөнгөөр усалгаа арилгаа нөхөн тарилтыг хийнэ гэж актанд тусган хүлээж аваад байна. | |
| 179 | Арга хэмжээ | 7.1.1 | Цөлжилтөд хүчтэй өртөж байгаа газар нутагт ганд тэсвэртэй тухайн орчинд тохирсон мод, бут тарьж ойн зурвас байгуулна. | га | Газрын доройтол, элсний нүүдлийн эсрэг ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ | 9.4 | 25 га | Чойбалсан хотын хөрсний судалгаа хийх ажлын тендерт ШУА-ын харьяа Геоэкологийн хүрээлэн гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулан судалгааны ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна. | 30 |
| 180 | | 7.1.2 | Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулна. | толгой | Шинээр нутагшуулсан ховор амьтны тоо толгой | 35 | 75 | “Меланж” ХХК-ийн санхүүжилтээр аймгийн хэмжээнд тоо толгой нь цөөрөөд байгаа 50 тоо толгой монгол тарвагыг Баянтүмэн сумын “Хутаг” ууланд нутагшуулаад байна. | 100 |
| 181 | | 7.1.3 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайг нөхөн сэргээнэ. | га | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | 0 | 158 | Тус аймгийн 2022 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 60 сая төгрөгөөр “Чойбалсан хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх” ажлыг 3.5 га талбайд, 20 сая төгрөгөөр “Улз голын эргийн нөхөн сэргээлт хийх” ажлыг 1.5 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгох ажил хийгдэж байна. Мөн уул уурхайн 2 аж ахуйн нэгжийн 2022 оны БОМТ-нд тухайн сум, орон нутгийн хэмжээнд эвдэрч, эзэнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Газрын тосны 19, 21 дүгээр талбайн 2020, 2021 онуудад хийгээгүй орхисон нөхөн сэргээлтийн ажлыг 2022 онд гүйцээлгэж хийлгэхээр аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна.<br>Баянтүмэн, Дашбалбар сумын нутагт эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газарт дүйцүүлэн хамгааллын хүрээнд нөхөн сэргээлт хийсэн “Шинь шинь”, “Меланж” ХХК-ийн ажлын үр дүнг газар дээр нь хянах ажлын хэсэг ажиллаж 8 га газрын хүлээн аваад байна. | |
| 182 | | 7.1.4 | *Түймэрт шатсан,* хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мод бэлтгэсэн газар жил бүр 150-аас доошгүй га талбайд ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийнэ. | хувь | Аймгийн нутаг дэвсгэрийн ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь. | 1.96 | 1.96 | Түймэрт шатсан, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мод бэлтгэсэн 50 га талбайд ойжуулалт хийх ажлын тендер Баявж-барас ххк шалгарч Баян-Уул сумын “Ар битүүгийн баруун бие” гэх газарт 50 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэн аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг газар дээр нь очиж тооллого зохион байгуулж ойжуулалтын амьдралын хувийг 78%-тай гэж үзэн хүлээн авсан. Тус аж ахуйн нэгж нь ойжуулалтын ажлаа 3 жил хариуцан өөрийн хөрөнгөөр усалгаа арилгаа нөхөн тарилтыг хийнэ гэж актад тусган хүлээж аваад байна. | 50 |
| 183 | | 7.1.5 | Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлнэ. | тоо | Байгаль орчны чиглэлээр ажиллаж буй ТББ-ын тоо | 3 | 10 | Сумдын байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтыг танхимаар, идэвхтэн байгаль хамгаалагчдад цахимаар сургалт зохион байгуулсан.<br>Энэ онд Баянтүмэн 1, Булган 4, Хөлөнбуйр 1, Цагаан-овоо 3 нийт 9 байгаль орчныг хамгаалах нөхөрлөл байгуулагдаад байна.<br>Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчдыг чадавхжуулах зорилгоор 2022 оны 6 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газартай хамтран зохион байгуулж “Зөрчлийн тухай”, “Зөрчил хянан шийдвэрлэх тухай” хууль, байгаль хамгаалагчдын эрх үүрэг, торгуулийн арга хэмжээг хэрхэн авах заавар зөвлөгөөг өгч голлон анхаарах асуудлыг тайлбарлан таниулах сургалтыг зохион | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулсан. | |
| Үнэт баялаг ус | | | | | | | | | |
| 184 | Зорилт | 7.2 | Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж гадаргын усны нөөцийг нэмэгдүүлнэ. | Сая м3 | Гадаргуугийн усны нөөцийн хэмжээ | 1510.0 | 1553.5 | Буйр нуур орчмын элсний нүүдэл сүүлийн жилүүдэд ихээр явагдах болсонтой холбоотой Буйр нуурын менежментийн төлөвлөгөөг 2021 онд газарзүй гео экологийн хүрээлэнгээр хийлгэсэн бөгөөд 2022 онд тус менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхийн тулд аймгийн БОХНСЗ-ын 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2.5 га талбайд ойн зурвас байгуулах газрын усалгааны систем хийхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах шатандаа явж байна. | 30 |
| 185 | Арга хэмжээ | 7.2.1 | Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна. | Сая м$^3$ | Ус хураах талбайн хэмжээ | Судалгаа, зураг төсөв хийгдсэн | 43.5 сая м3 ус хураах талбай бүхий нуур үүснэ. | Буйр нуур орчмын элсний нүүдэл сүүлийн жилүүдэд ихээр явагдах болсонтой холбоотой Буйр нуурын менежментийн төлөвлөгөөг 2021 онд Газарзүй геоэкологийн хүрээлэнгээр хийлгэсэн бөгөөд 2022 онд тус менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхийн тулд аймгийн БОХНСЗ-ын 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2.5 га талбайд ойн зурвас байгуулах газрын усалгааны систем хийхээр худалдан авах ажиллагаа 3 удаа зарлагдаж оролцогч байхгүйн улмаас ажил хийгдээгүй байна. | 30 |
| 186 | | 7.2.2 | Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ: | хувь | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь | 20.7 | 25.6 | Хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийлгэх ажлын төсөв батлагдаагүй. 2023 онд Адапт төслийн санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөж байна. | 0 |
| | | | | хувь | Усны хамгаалалтын бүс тогтоосо | 9.44 | 10.0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | н талбайн эзлэх хувь. | | | | |
| Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил | | | | | | | | |
| 187 | Зорилт | 7.3 | Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, хог хаягдлын хэмжээг бууруулна: | хувь | Хот, суурин газрын хог хаягдлыг тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь | 30.0 | 75.0 | Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийн ерөнхий төлөвлөгөө, ландфиллийн байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажлыг барилгын мэргэжлийн байгууллага болох “Мишээл Кристалл Хаус”ХХК-аар хийлгээд байна. Шинээр байгуулах хогийн цэгийг хашаажуулах ажлыг 2021 онд 440 м төмөр торон хашаа хийж, 2022 онд 541 м урттай төмөр торон хашааны ажил хийгдээд байна. | 50 |
| 188 | Арга хэмжээ | 7.3.1 | Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулна. | хувь | Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээний таарц, онч, гамшигт үзэгдлийн илрүүлэлт | 91.6 | 93.0 | Тайлант онд анхааруулах мэдээ 13 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 3 зарлаж таарц, онч 100 хувь байна. Alarm-д Анхааруулах мэдээ 13 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 6 удаа тус тус дамжуулсан Онч 100 хувьтай, өмнөх оноос 2.1 хувь ахиулсан байна. | 70 |
| 189 | | 7.3.2 | Бэлчээрийн төлөв байдлын судалгааг нарийвчлан тогтоож | | Тухайн жилийн | | | Бэлчээрийн төлөв байдлын судалгаа хийх хугацаа болоогүй. | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үнэлэн зохистой менежмент хэрэгжүүлнэ. | хувь | бэлчээрийн даац, багтаамж бэлчээрийн хүртээмж | 90 | 80-90 | | |
| 190 | | 7.3.3 | Агаар, хөрсийг бохирдуулагчийн тоог бууруулах дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, агаарын бохирдлыг бууруулна. | мкг/м$^3$ | Аймгийн төвийн агаар дахь PM 2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж | 45 | 25 | PM-2.5, 10, тоосонцрыг 24 цагаар нийт 151 удаагийн хэмжилт хийн мэдээ мэдээллийг 45 удаа www.dornod.tsag-agaar.gov.mn, Ус, Цаг уурын орчны шинжилгээний төвийн Facebook хуудсаар хүргэсэн.<br>PM-2.5 тоосны дундаж агууламж нь 23 мкг/м$^3$ PM-10 тоосны жилийн дундаж агууламж нь 45 мкг/м$^3$ буюу MNS4585:2016 стандартын дагуу байна. | 100 |
| | | | | мкг/м$^3$ | PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж | 56 | 50 | | |
| 191 | | 7.3.4 | Үүлэнд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ | тоо | Экспедицийн тоо | 2 | 3 | 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Онон Бороо-1 экспедиц 2 удаа, Онон Бороо-2 экспедиц 4 удаа гарсан ба 3 удаа түймрийн голомт дээр ажилласан<br>Баян-Уул сумын нутагт гарсан хээрийн түймэрт 1 удаа, Халхголын нутагт гарсан хээрийн түймэрт 2 удаа үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж, түймрийн цурмыг унтрахад тус нэмэр болж амжилттай ажилласан. | 100 |
| 19 | | 7.3.5 | Хог хаягдлыг дахин | хувь | Дахин | 8.5 | 40.0 | Чойбалсан хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | | боловсруулах, дахин ашиглах менежментийг сайжруулна. | | боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь | | | Баянтүмэн сумын 3 дугаар баг Буяны хонхор гэдэг газар төлөвлөгдсөн. Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийн ерөнхий төлөвлөгөө, ландфиллийн байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажлыг барилгын мэргэжлийн байгууллага болох “Мишээл Кристалл Хаус” ХХК-иар хийлгээд байна. Шинээр байгуулах хогийн цэгийг хашаажуулах ажлыг 2021 онд 440 м төмөр торон хашаа хийж, 2022 онд 541 м урттай төмөр торон хашааны ажил хийгдээд байна. Энэ онд хог хаягдлыг ангилан ялгах цех байгуулах бараа материалыг ОНТ-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ажлын 350 сая төгрөгийн тендерт “Өршөөлтийн арвин”ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулж, бараа материал нийлүүлээд байна. Дашбалбар сум орон нутгийн хөгжлийн сангийн 285,5 сая төгрөгийн санхүүжилтээр хатуу хог хаягдлын ландфиллийн байгууламжийн ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр “Мишээл Кристалл Хаус”ХХК-аар зураг, төсвийн дагуу хийлгэж ашиглалтанд хүлээн аваад байна. | |
| НАЙМ. СУМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ | | | | | | | | | |
| Дэд бүтэц | | | | | | | | | |
| 193 | Зорилго | 8 | Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадвартай аймаг, сумыг хөгжүүлнэ. | оноо | Өрсөлдөх чадварын үзүүлэлт | 87.14 | 95.0 | Өрсөлдөх чадварын үзүүлэлт гарах хугацаа болоогүй байна. | 0 |
| 194 | Зорилт | 8.1 | Дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулна. | оноо | Сумдын өрсөлдөх чадварын үзүүлэлт | - | 85.0 | Энэ онд хийгдэх төсөв батлагдаагүй тул хойшлогдсон. | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 195 | Арга хэмжээ | 8.1.1 | Аймгийн төв, стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барина. | км | Шинээр баригдах улсын чанартай хатуу хучилттай авто замын урт | 159 | 564.5 | Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт хүртэл 124.5 км замын зураг төсөл, хайгуулын ажлыг 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн. Нийт төсөвт өртөг 114,044,900,000 төгрөг.<br>Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу 2022 оны улсын төсөвт 12,511,900,000 төгрөгийг тусган баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 5 удаа зарласан боловч гүйцэтгэгч тодроогүй байна.<br>Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэл хатуу хучилттай 50 км авто зам барих ажлын нийт төсөвт өртөг – 49,8 тэрбум төгрөг ба ажлыг 2022-2024 онд хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны улсын төсөвт 10,5 тэрбум төгрөг батлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 5 удаа зарласан боловч шаардлага хангасан оролцогч байхгүй тул энэ онд хэрэгжээгүй байна.<br>Төмөр замын чиглэлээр 2022 онд ажил хийгдээгүй. | 50 |
| | | | | км | Шинээр баригдах төмөр замын урт | - | 427.1 | | |
| 196 | | 8.1.2. | Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, тээвэр логистикийн төв байгуулна. | тоо | Тээвэр логистикийн шинээр нэмэгдэх төв | 0 | 1 | Тээвэр ложистикийн төв барих газрын байршлыг тогтоох ажил хийгдэж байна. Барилгын ажлын хөрөнгө шийдэгдээгүй. | 0 |
| 197 | | 8.1.3. | Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймаг, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад | 0<br>1 | Мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолбор | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.3.11.2-т “Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх зорилгоор хот | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулна. | | байгуулагдсан эсэх | | | суурин газруудад аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах цамхаг, цогцолбор байгуулах ажил”-ыг 2023 онд Чойбалсан, 2024 онд Матад суманд тус тус байгуулахаар тусгагдсан байна.<br>Тус ажлын бэлтгэл байдлыг хангаж энэ онд “АСА” цогцолборын зохион бүтээгч н.Тогтох Дорнод аймагт 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд ажиллан Аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах, цогцолбор байгуулах байршил, цахилгааны эх үүсвэрийг зөвшилцөн шийдвэрлэсэн. 1-р үе шатны судалгааны ажил хийгдэж дууссан. | |
| 198 | | 8.1.4 | Хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлнэ. | хувь | Хилийн боомт дээрх хэрэгжиж буй төслийн хэрэгжилт | 0 | 100 | 0188 дугаар салбар /Задгайт/-ын албаны байр, 6 айлын орон сууцыг шинээр барих ажил 70 хувьтай явагдаж байна. Хилийн цэргийн 0104 дүгээр салбар /Баянхошуу/-т 6 айлын барилга баригдсан. Хилийн 0275 дугаар ангийн 0266, 0307 дугаар салбаруудад (Гэрээт цэргийн байр, 16 айлын орон сууц)-ийг шинээр барихаар ХХЕГ-аас 2023 онд барилга байгууламжийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд багтсан. Хилийн 0198 дугаар ангид хилийн Баянхошуу, Сүмбэр боомтуудад 16 нэр төрлийн 62 ширхэг шалгалтын техник хэрэгслийг шинээр суурилуулан албанд ашиглаж байна Хилийн 0275 дугаар ангид ХХЕГ-аас 2022 онд Улсын хилийн боомтын шалган нэвтрүүлэх албанд 22 техник хэрэгслийг нэвтрүүлсэн. Хилийн 0179 дүгээр салбарын хариуцсан хэсэгт шинээр телекамер суурилуулах зорилгоор хянах цамхаг шинээр барьсан. | 70 |
| 199 | | 8.1.5 | Чойбалсан нисэх буудлын хүчин чадлыг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлж, сумдад нисэх онгоцны буудал байгуулна. | тоо | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 0 | 2 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 13,0 сая төгрөгийн санхүүжилтээр Халхгол суманд нисэх онгоцны буудал барих ажлын зураг төсвийг шинэчлүүлэн хүлээн авсан.<br>Аймгийн 2022 оны төсвийн 140,0 сая төгрөгийн | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ийн хүрээнд сумдад баригдсан нисэх буудлын тоо | | | хөрөнгөөр өмнө онд ажлыг эхлүүлсэн Баяндун, Халхгол сумдын нисэх онгоцны буудлын ажлыг үргэлжлүүлэн зам талбай, цахилгаан эрчим хүч, барилга, тохижилтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хөрөнгийн асуудлаас шалтгаалан төсвийн тодотголоор хасагдсан. | |
| 200 | | 8.1.6 | Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг зам, тээврийн салбарт нэвтрүүлж, ухаалаг тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | тоо | Цахилгаан болон хийгээр цэнэглэдэг тээврийн хэрэгслийн тоо | Цах-4 Хий-199 | Цах-20 Хий-400 | Тээврийн хэрэгслийн бүртгэл, судалгаа жилийн эцсийн байдлаар гарна. Хугацаа болоогүй. | 0 |
| 201 | | 8.1.7 | "Аймаг, сумын бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалт" төсөлтэй хамтран түүхийн дурсгалт барилга байгууламжийг засварлах, төмөр бетон гүүр барих, гэр хороололд инженерийн шугам сүлжээ барих ажлыг хэрэгжүүлнэ. | 01 | Төсөл хэрэгжсэн эсэх | 0 | 1 | 2014 онд “ХЗТ автозам” ХХК-ийн боловсруулсан Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр дэх дунд модон гүүрийг 2 урсгалтай төмөр бетон гүүр болгон шинээр барих зураг төсвийг шинэчлэх ажлыг 2022 онд хэрэгжүүлсэн. Гүүр барих хөрөнгийг 2022 оны улсын төсөвт төсөвт суулгах саналыг хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй.<br>Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Чойбалсан хотын /хуучин төв/ 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах” ажлын даалгаврын дагуу зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 5 дугаар баг, үйлдвэрлэлийн бүс рүү цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын зураг төсөв боловсруулах, Хэрлэн сумын 4 | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгээр багт дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөлийн ажлын зураг төсөв боловсруулах, Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт инженерийн шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлыг тус тус хэрэгжүүлсэн. Эдгээр инженерийн шугам сүлжээ баригдсанаар Хэрлэн сумын хэмжээнд инженерийн шугам сүлжээний хүрэлцээ хангамж нэмэгдэж, гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах боломж бүрдэнэ. | |
| 202 | | 8.1.8 | Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлж, төвлөрсөн инженерийн шугам сүлжээг барина. | 01 | Төсөл хэрэгжсэн эсэх | 0 | 1 | “Сумын хөгжил” төсөл 2022 онд Дашбалбар суманд хэрэгжихээр батлагдаж, ажлын гүйцэтгэгчээр “Чандмань тал” ХХК шалгарч сумын төвийг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг гүйцэтгэж байна. Энэ онд хэрэгжих ажил дууссан. | 100 |
| 203 | | 8.1.9 | Сумдыг эдийн засгийн ач холбогдлоор нь бүсчилэн кластер загвараар хөгжүүлнэ. | хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт | 0 | 4 | Шинэ сэргэлтийн бодлоготой холбоотойгоор Дорнод аймаг, Халхголын бүс нутагт орон нутагт хөгжүүлэх боломжтой хөнгөн үйлдвэрлэлийн салбарын танилцуулгыг боловсруулсан. | 30 |
| Хэрэгжилтийн дундаж хувь | | | | | | | | **74.9** |

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР